# ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



НЭГ.ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1.1 УДИРТГАЛ ХЭСЭГ

ХОЁР.ҮНДСЭН ХЭСЭГ

2.1.ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.1.1.Хэргийн хөдөлгөөний удирдлага
2.1.2.Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийг сонгон шалгаруулах, ажиллуулах, тангараг өргүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа
2.1.3. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа
2.1.4.Шүүхийн мэдээллийн технологийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа
2.1.5.Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
2.1.6.Шүүхийн бие даасан байдлыг хангах талаарх бусад үйл ажиллагаа
2.1.7.Дүн шинжилгээ

2.2.ШҮҮХИЙГ ХҮНИЙ НӨӨЦӨӨР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.2.1.Шүүхийн хүний нөөцийг бүрдүүлэх, сул орон тоог тухай бүр нөхөх, хүний нөөцийн программ ашиглалтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
2.2.2.Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлт
2.2.3.Шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах
2.2.4.Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулах
2.2.5.Шүүгч ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээрх үйл ажиллагаа
2.2.6.Төрийн албан хаагчийн ёс зүйг хангуулах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
2.2.7.Бусад
2.2.8.Дүн шинжилгээ

2.3.ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.3.1.Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
2.3.2.Шүүхийн аюулгүй байдлыг хангах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
2.3.3.Шүүгчийн хараат бус, аюулгүй байдлыг хангах хүрээнд урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
2.3.4.Дүн шинжилгээ

## 2.4.ШҮҮХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.4.1.Батлагдсан төсөв, цалингийн сан, орон тоонд багтаан төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулах, бүртгэх, тайлагнах ажлыг зохион байгуулах

2.4.2.Шүүхийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, норм стандартын дагуу үндэслэлтэй боловсруулах

2.4.3.Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг иж бүрэн, үнэн зөв, хуульд заасан хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх

2.4.4.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан анхан шатны баримтын бүрдлийг хангах

2.4.5.Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангах

2.4.6.Ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах, шилжүүлэх эсхүл худалдах асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлүүлж биелэлтийг хангаж ажиллах

2.4.7.Цалин, хөлс, татвар, даатгалын тайлангийн уялдааг хангах, өр авлагагүй ажиллах

2.4.8.Төрийн цахим худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайтыг ашиглах, ил тод нээлттэй байлгах, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх талаар

2.4.9.Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд www.shilendans.gov.mn сайтад үнэн зөв иж бүрэн байршуулах

2.4.10.Дүн шинжилгээ

## 2.5.МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.5.1.Шүүхийн цахим хуудас мэдээллийн самбар хөтлөлт

2.5.2.Шүүхийн шийдвэртэй холбоотой мэдээлэл бэлтгэж, мэдээлсэн байдал

2.5.3.Шүүх хуралдааны талаар олон нийтийг мэдээллээр хангах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

2.5.4.Бусад

2.5.5.Дүн шинжилгээ

# ГУРАВ.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

## 3.1.ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ САЙЖРУУЛАХ САНАЛ

# ДӨРӨВ.ХАВСРАЛТ

## 4.1.ТУХАЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ШҮҮГЧ, АЖИЛТНЫ ӨГСӨН ҮНЭЛГЭЭ /Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, тэмдэглэл/

# УДИРТГАЛ ХЭСЭГ

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тамгын газар нь 2025 оны үйл ажиллагааны тайланг 2024 оны 12 сарын 23-ны өдрөөс 2025 оны 11 сарын сарын 19-ний өдрийг хүртэлх хугацааг хамруулж гаргав.

Шүүхийн тамгын газрын тайланг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 33-р тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан бүтцийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 11 сарын 17-ны өдрийн 01/1852 тоот “Тамгын газрын үйл ажиллагааны бүтэн жилийн тайлан” ирүүлэх тухай албан бичгийн дагуу гаргаж хүргүүллээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх нь 2025 онд хүний нөөцийн хувьд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс баталсан 19 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Хүний нөөцийн хувьд тогтвор суурьшилтай, мэргэшсэн хамт олноор багаа бүрдүүлж, шүүхийн захиргааны ажилтнуудын ажил хариуцах чадвар, хариуцлагыг дээшлүүлэх, мэргэших үйл явцыг сайжруулахад зорилго нэгтэй ажиллаж байна.

Шүүхийн үндсэн үйл ажиллагаа болох шүүн таслах үйл ажиллагааг хэвийн явуулах, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар хандсан иргэдийн асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэхэд зохигчдын хууль ёсны эрхийг хангах, шүүхээс үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдал, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхийг зорилго болголоо. Тайлангийн хугацаанд иргэд, олон нийтээс тус шүүхийн шүүгч, шүүхийн Тамгын газар, шүүхийн захиргааны ажилтнуудтай холбоотой гомдол, өргөдлийг ирүүлээгүй нь тус шүүхийн тамгын газрын ажлын үр дүн юм.

Шүүхийн үйлчилгээг орон нутгийн онцлогт тохируулан нутгийн захиргааны байгууллага болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран нэгдсэн төлөвлөгөөний дагуу хөдөө орон нутгийн иргэдэд хүрч шүүхийн үйлчилгээ үзүүлэх, мөн түүнчлэн шүүхийн үйл ажиллагааг сурталчлах, шүүхийн шинэтгэлийн үр дүнг таниулах зорилгоор нүүдэллэн ажилласан.

Тус шүүхийн тамгын газрын шүүхийн үйлчилгээний соёл, шүүхийн захиргааны ажилчдын мэдлэг, ур чадвар дээшилж, ажиллах орчин нөхцөлийг нь өнөөгийн боломжит түвшинд бүрэн хангаж ажилласан.

Цаашид шүүхийн салбарын ололт, амжилтыг бататган, орон нутагт шүүхийн үйл ажиллагааг чирэгдэлгүй, ил тод нээлттэй хүргэх бүхий л боломжийг дэлгэрүүлэн шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг улам бүр бэхжүүлэн ажиллах болно.

## ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

### 1.1.Хэргийн хөдөлгөөний удирдлага

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2024 оны 12 сарын 23-ны өдрийн 01 дугаартай, 2025 оны 05 сарын 19-ний өдрийн 05 дугаартай “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг батлах тухай” тогтоолуудын дагуу тус шүүхийн мэдээлэл лавлагааны мэргэжилтэн эрүүгийн хэрэг, зөрчлийн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг “Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем”, “Иргэн 2014” программуудад бүртгэн хүлээн авч, холбогдох бүртгэлийн дэвтрүүдэд бүртгэн шүүгчид тухай бүрд хүлээлгэн өгч ажиллалаа.


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ

2024 12 23 137/ЗТ2025/01

Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журамд өөрчлөлт оруулах тухай

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч Д.Цэдэнпэлжээ даргалж, шүүгч Э.Болормаа оролцуулан, нарийн бичгийн дарга М.Энхцэцэгийг байлцуулан хийсэн 2025 оны шинэ оны ажил эхлэх байгаатай холбогдуулан хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг батлах асуудлыг хэлэлцэв.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 19 дугаар зүйлийн 19.1, 19.2.2, 19.2.5, 19.3.1, 19.3.2, 19.8, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2, 5, 3.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 78 дугаар зүйлийн 78.1, 78.2, 78.6 дахь хэсэг, Нийт шүүгчдийн чуулганы хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 05 дугаар тогтоол, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Нийт шүүгчдийн чуулганы 2023 оны 09 сарын 28-ны өдрийн 04 дугаар тогтоолд заасныг тус, тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчдийн дарааллыг тогтоох /Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19.2.5/

1.1. Хуульд заасан болон шүүгч удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ хэрэгжүүлэхгүй байгаагаас бусад тохиолдолд шүүгчид хэрэг, нэхэмжлэл, өргөдөл гомдол, хүсэлтийг алгасахгүйгээр хуваарилсугай.

1.2.Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хуваарилах шүүгч болон хуралдаан даргалагчийг сугалаагаар дараах байдлаар тогтоосугай.

а.Эрүүгийн хэргийг бүртгэл, хяналтын системд
- Ерөнхий шүүгч Д.Цэдэнпэлжээ


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ

2025 05 19 2025/ЗТ/05

Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журамд өөрчлөлт оруулах тухай

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч Э.Болормаа даргалж, нарийн бичгийн дарга М.Энхцэцэгийг байлцуулан хийсэнээлжит бус хуралдаанаар шүүгч Д.Цэдэнпэлжээг өндөр насны тэтгэвэрт гаргасан 2025 оны 05 сарын 15-ны өдрийн 60 тоот Ерөнхийлөгчийн зарлигийг 2025 оны 05 сарын 19-ны өдөр хүлээн авч хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журамд өөрчлөлт оруулахаар хэлэлцэв.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 19 дугаар зүйлийн 19.1, 19.2.2, 19.2.5, 19.3.1, 19.3.2, 19.8, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2, 5, 3.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 78 дугаар зүйлийн 78.1, 78.2, 78.6 дахь хэсэг, Нийт шүүгчдийн чуулганы хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 05 дугаар тогтоол, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Нийт шүүгчдийн чуулганы 2023 оны 09 сарын 28-ны өдрийн 04 дугаар тогтоолд заасныг тус, тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах шүүгчдийн дарааллыг тогтоох /Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19.2.5/

1.1. Хуульд заасан болон шүүгч удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ хэрэгжүүлэхгүй байгаагаас бусад тохиолд...

2024 оны 12 сарын 23-ны өдрийн 01 дугаартай, 2025 оны 05 сарын 19-ний өдрийн 05 дугаартай “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг батлах тухай” тогтоолуудын дагуу тус шүүхийн мэдээлэл лавлагааны мэргэжилтний 2024.12.23-2025.11.19-ний өдрийн байдлаар нийт хүлээн авсан хэргийн тоо мэдээ:






Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад:

2024 онд Эрүүгийн 146 хэрэг хүлээн авсан нь энэ онтой харьцуулахад 140 хэрэг буюу 4,1%-аар буурсан, иргэний нэхэмжлэл 340 хүлээн авсан нь 844 нэхэмжлэл буюу 148,2%-аар өссөн, зөрчлийн хэрэг 1278 хүлээн авсан нь 1541 хэрэг буюу 20,5%-аар өссөн, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны өргөдөл 151 хүлээн авсан нь 250 өргөдөл буюу 65,6%-аар өссөн үзүүлэлттэй байна.



**Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аргачлал, журмын хэрэгжилтийг хангах ажиллагааны талаар:**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 158 дугаартай “Хэргийн хөдөлгөөний хяналтын журам батлах” тухай тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Дотоод хяналт шалгалтын маягт”-ын дагуу бүртгэлийн дэвтэр болон системд хяналт, шалгалт хийхэд хэрэг, нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг хүлээн авах, хүргүүлэх, бүртгэх ажиллагаа зөрчилгүй, зарим дэвтрийг засвартай хөтөлснийг улирал бүр Тамгын газрын дотоод хяналт шалгалты маягтад заасны дагуу хугацаанд нь хүргүүлсэн болно.




Тус шүүхийн архивд 2025 онд хүлээлгэн өгсөн эрүү, иргэн, зөрчил, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны материалаас хянан шийдвэрлэсэн эрүү, иргэн, зөрчлийн 5, 5 хэргийг сонгон авч хяналт шалгалтыг 2 удаа хийж хэргийн баримтуудыг аргачлалд заасны дагуу хэрэгт бүрдүүлж, хэрэгт бүрдүүлсэн баримтын дугаар, огноо программ дахь баримтуудын огноотой таарч байгаа эсэх, эрх зүйн актууд хэрэг болон программд тохирч байгаа эсэх, хугацаандаа бүрэн албажсан эсэх, шүүхийн шийдвэр, шийтгэх тогтоол, шийтгэврийг хугацаандаа гардуулсан эсэхэд тус тус хяналт шалгалт хийж хамт олны шуурхай зөвлөгөөнд алдаа, зөрчлийг танилцуулж ажилласан. Дээрх хяналт шалгалтаар баримтуудыг батлагдсан баримтын загварын дагуу үйлдэж хэрэгт хавсаргаж байгаа боловч нийтлэг гарч байгаа алдаа нь баримтын дугаар хэрэг, программд зөрж, “иргэний хэргийг архивт хүлээлгэж өгөхдөө программыг бөглөж” байгаа зөрчил илэрснийг шүүгчийн туслахуудад анхааруулсан.



Мэдээлэл лавлагааны мэргэжилтний эрүү, иргэний системүүдэд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол хүсэлт, бүртгэх үйлдэл бүрд дүрс бичлэг хийгдэж, бичлэгийн бүртгэлийн мэдээг 7 хоног бүр мэдээлэл лавлагааны мэргэжилтэн гаргаж шүүгч, ажилчдын шуурхай зөвлөгөөнд танилцуулж, хяналт тавин ажиллаж байна.

/2025.11.10-2024.11.19-ний өдрийн байдлаар/

| Д/Д | Программаар хүлээн авсан бүртгэлийн нэр | Хүлээн авсан тоо |
|---|---|---|
| | **1.ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ** | |
| 1 | Эрүүгийн хэрэг | 3 хэрэг |
| 2 | Эрүүгийн хэрэгт гаргасан давж заалдах гомдол | 0 гомдол |
| 3 | Эрүүгийн хэрэгт гаргасан хяналтын гомдол | 0 гомдол |
| 4 | Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хүсэлт | 3 хүсэлт |
| 5 | Таслан сэргийлэх арга хэмжэний санал | 0 Санал |
| 6 | Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах санал | 0 Санал |
| 7 | Албадан ирүүлэх тухай хүсэлт | 0 хүсэлт |
| 8 | Эрүүгийн хэрэгт ял солих | 0 хүсэлт |
| | **2.ЗӨРЧЛИЙН ХЭРЭГТ** | |
| 1 | Зөрчлийн хэрэг | 17 хэрэг |
| 2 | Зөрчлийн хэрэгт гаргасан давж заалдах гомдол | 0 гомдол |
| 3 | Шийтгэлийн хуудсыг албадан гүйцэтгүүлэх хүсэлт | 0 хүсэлт |
| 4 | Зөрчлийн хэрэгт хүсэлт | 0 хүсэлт |
| 5 | Гүйцэтгэх хуудас хүчингүй болгуулах хүсэлт | 0 хүсэлт |
| | **3.ИРГЭНИЙ ХЭРЭГТ** | |
| 1 | Нэхэмжлэл | 48 нэхэмжлэл |
| 2 | ГШБ хүсэлт, эвлэрлийн гэрээ | ГШБ хүсэлт-15, эвлэрлийн гэрээ-7 |
| 3 | Өөр шүүхээс ирсэн даалгавар | 2 даалгавар |
| 4 | Давж заалдах гомдол | 1 гомдол |
| 5 | Хяналтын журмаар гаргасан гомдол | 0 гомдол |
| 6 | 170 гомдол | 0 гомдол |
| 7 | Хүчингүй болсон хэрэг хувиарласан | 0 хэрэг |
| 8 | Сөрөг нэхэмжлэл | 0 нэхэмжлэл |
| | **screen record бичлэг-96** | |

**/Мэдээлэл лавлагааны мэргэжилтний хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол хүсэлт хүлээн авсан дэлгэцний /screen record/ бичлэгийн мэдээ/**

Тус шүүхийн мэдээлэл лавлагааны мэргэжилтэн өдөр бүр системын хандалт бүрийг дүрс бичлэгээр баталгаажуулан ажиллаж, сар бүр хүлээн авсан хэрэг, нэхэмжлэл, өргөдөл гомдлын тоогоор тулган Мэдээлэл технологийн мэргэжилтэн сард сард нь архивлан Шүүгч ажилчдын шуурхай зөвлөгөөнд танилцуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 100GB хэмжээ бүхий 708 бичлэгийг хадгалан архивласан ба уг ажиллагаанд Тамгын газрын дарга хяналт тавин ажиллаж байна.




**/Screen record дэлгэцийн бичлэгийг архивлан хадгалсан байдал/**

Эрүү, Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалын тогтоолын хавсралтад өөрчлөлт орсонтой холбогдуулан шүүгчийн туслахууд бүрэн эзэмшиж, хэргийн хөдөлгөөний программын хөтлөлтийг хэрхэн хангаж эрх зүйн актуудыг хугацаанд нь албажуулж ажиллаж байгаа 7 хоног бүр шүүхийн тамгын газрын даргын гаргасан удирдамжийн дагуу мэдээлэл технологийн мэргэжилтэн тухай бүр шалгаж, шалгалтын үеэр гарсан зөрчил дутагдлыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн гаргасан алдаа дутагдлыг засуулах ажлыг зохион байгуулж байна.

**Шүүгчийн шүүн таслах ажиллагааны ачааллыг судлах, хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, үзүүлэлт, хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр судалгаа хийж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулах**

Тус шүүх нь долоо хоног бүрийн даваа гарагийн 08 цаг 30 минутаас хийдэг "Шүүгч, ажилтан, албан хаагчдын шуурхай зөвлөгөөн"-өөр өмнөх долоо хоногт хийсэн ажлын мэдээг танилцуулж, хяналт тавьж хэвшсэн. Тус шуурхай зөвлөгөөнөөр шүүн таслах ажиллагаатай холбоотой болон шүүх, шүүхийн тамгын газрын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой дараах мэдээ, мэдээлэл, тайланг танилцуулж байна.

| | |
|---|---|
| ✓ | Эрүү, Иргэн, Зөрчлийн хэрэг хүлээн авч, шийдвэрлэсэн байдлын мэдээг шүүгч тус бүрээр, |
| ✓ | Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний санал хүлээн авч шийдвэрлэсэн мэдээ, |
| ✓ | Өргөдөл, гомдол хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн мэдээ, |
| ✓ | Давж заалдах, хяналтын журмаар шийдвэрлэсэн хэргийн мэдээ, |
| ✓ | Тухайн долоо хоногт зарласан шүүх хуралдааны хойшилсон, цагтаа эхэлсэн эсэх талаарх мэдээ, |
| ✓ | Хянан шийдвэрлэсэн эрүү, иргэн, зөрчлийн хэргийн тойм мэдээ, |
| ✓ | Мэдээлэл лавлагааны мэргэжилтний тухайн долоо хоногт эрүү, иргэний хэргийн нэгдсэн системийн үйлдэл бүрийг дүрс бичлэгээр баталгаажуулсан байдлын мэдээ, |
| ✓ | Шүүх хуралдааны үйл явцыг **https://live.shuukh.mn/** программд бүрэн гүйцэт хөтөлсөн эсэх мэдээ, |
| ✓ | Эвлэрүүлэн зуучлалын мэдээ, |
| ✓ | Архивын мэдээ, |
| ✓ | Бичиг хүргэлтийн мэдээ, |
| ✓ | Шүүхийн шийдвэрийн цахим сангийн мэдээ, |
| ✓ | Эрх зүйн актууд хугацаандаа албажсан эсэх мэдээ, |
| ✓ | Шүүх хуралдааны бичлэг хүлээн авсан мэдээ, |
| ✓ | Ажлын цаг ашиглалтын мэдээ, |
| ✓ | Тамгын газрын даргаас гаргасан тушаал шийдвэрийн танилцуулга, |
| ✓ | Нягтлан бодох бүртгэлийн мэдээ |

Шуурхай зөвлөгөөнөөр шүүн таслах ажил болон тамгын газрын хийвэл зохих, мөн хийсэн ажлуудыг ажилтан тус бүрээр дүгнэж ярилцдаг нь ажилтан, алба хаагчдын ажлын хариуцлага, дэг журам сайжрахад сайнаар нөлөөлж байгаа бөгөөд хэргийн хөдөлгөөний алдаа, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд тодорхой нөлөөлж байгаа юм.






Тухайн 7 хоногт нэгдсэн системээс гарсан эрх зүйн актуудыг хугацаанд нь албажуулж, программд бүрэн гүйцэт оруулж байгаа эсэхэд, мөн өмнөх долоо хоногийн шуурхай зөвлөгөөнөөр батагаажуулаагүй эрх зүйн акт хугацаандаа баталгаажсан эсэхэд дараах байдлаар хяналт тавьж, мэдээлэл технологийн мэргэжилтэн мэдээлэл бэлтгэж шуурхай зөвлөгөөнд танилцуулж хэвшсэн. Энэ ажил нь хэргийн хөдөлгөөнд алдаа, зөрчил гаргахгүй ажиллахад тус шүүхээс онцгой анхаарч хяналт тавьж буй нэг хэлбэр юм.




***/эрүү, зөрчлийн хэргийн эрх зүйн актууд хугацаандаа албажсан эсэхэд хяналт тавьж буй байдал/,***




*/иргэний хэргийн эрх зүйн актууд хугацаандаа албажсан эсэхэд хяналт тавьж буй байдал/,*
*/цэнхэр бичигтэй “false” гэсэн нь хуулийн хугацаандаа байгаа гэж ойлгоно/*

**Эвлэрлийн гэрээ – 160 бүгд орсон**

| № | Дугаар | Огноо | Өргөдөл гаргагч | Уригдагч | Зуучлагч | Бүрэн эсэх | Бүрэн хадгалсан огноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 137/ЭГ2025/00160 | 2025-11-11 | Соно Финтек ББСБ-ХХК | М.Баянзул | С.Баяржаргал | TRUE | 2025-11-11 |
| 2 | 137/ЭГ2025/00159 | 2025-11-10 | Э.Золзаяа | Ч.Азжаргал | С.Баяржаргал | TRUE | 2025-11-10 |
| 3 | 137/ЭГ2025/00158 | 2025-11-10 | Д.Гомбо | Ж.Энх-Отгон | С.Баяржаргал | TRUE | 2025-11-10 |

**Тэмдэглэл –341 бүгд орсон**

| № | Дугаар | Огноо | Өргөдөл гаргагч | Уригдагч | Зуучлагч | Бүрэн эсэх | Бүрэн хадгалсан огноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 137/ЭТ2025/00341 | 2025-11-11 | Соно Финтек ББСБ-ХХК | М.Баянзул | С.Баяржаргал | TRUE | 2025-11-11 |
| 2 | 137/ЭТ2025/00340 | 2025-11-11 | Ж.Чагцал | Т.Нарантуяа | С.Баяржаргал | TRUE | 2025-11-11 |
| 3 | 137/ЭТ2025/00339 | 2025-11-10 | Э.Золзаяа | Ч.Азжаргал | С.Баяржаргал | TRUE | 2025-11-10 |

**Шүүгчийн ачааллын судалгааны талаар:**

Тус шүүхийн шүүгчдийн хүлээн авч хянан шийдвэрлэсэн эрүү, иргэн, зөрчлийн хэрэг болон боловсруулсан 2024 оны эрх зүйн актуудыг 2025 оныхтой харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

| Огноо | Эрүүгийн хэрэгт боловсруулсан эрх зүйн актууд | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шийтгэх тогтоол | Ерөнхий шүүгчийн захирамж | Шүүгчийн захирамж | Шүүхийн тогтоол | Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол | Шүүх хуралдааны тэмдэглэл | ТСАХ шүүгчийн захирамж | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа | Гүйцэтгэх хуудас |
| 2024 | 148 | 1609 | 399 | 3 | 42 | 211 | 25 | 1 | 214 |
| 2025.11.19 | 133 | 1711 | 349 | 6 | 7 | 180 | 18 | 3 | 263 |

**/2024, 2025 онд тус шүүхийн боловсруулсан эрүүгийн эрх зүйн актуудын тоон үзүүлэлт/**

| Огноо | Иргэний хэрэгт боловсруулсан эрх зүйн актууд | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Шүүхийн шийдвэр | Ерөнхий шүүгчийн захирамж | Шүүгчийн захирамж | Шүүхийн тогтоол | Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол | Шүүх хуралдааны тэмдэглэл | Гүйцэтгэх хуудас |
| 2024 он | 304 | 400 | 972 | 10 | 29 | 128 | 355 |
| 2025.11.19 | 674 | 897 | 1893 | 6 | 35 | 193 | 800 |

***/2024, 2025 онд тус шүүхийн боловсруулсан иргэний эрх зүйн актуудын тоон үзүүлэлт/***

| Огноо | Зөрчлийн хэрэгт боловсруулсан эрх зүйн актууд | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Шийтгэвэр | Шүүгчийн захирамж | Шүүх хуралдааны тэмдэглэл | Гүйцэтгэх хуудас | Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлт |
| 2024 он | 1491 | 2166 | 1522 | 901 | 629 |
| 2025.11.19 | 1539 | 1565 | 1554 | 445 | 8 |

***/2024, 2025 онд тус шүүхийн боловсруулсан зөрчлийн эрх зүйн актуудын тоон үзүүлэлт/***

**Шүүх хуралдаан хойшлолтын талаар судалгаа:**

2024, 2025 онуудын шүүх хуралдаан хойшлолтын нөхцөл, шалтгааны талаар судалгааг гаргалаа.




**Хойшилж буй шүүх хуралдааны талаарх дүгнэлт, цаашид анхаарах асуудал:**

Тус онд зарлагдсан шүүх хуралдаан олон удаа хойшлох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, шүүхэд итгэх иргэдийн итгэл буурах сөрөг үр дагаврыг үүсгэдэг. Иймд цаашид шүүх хуралдаан товлогдохоос өмнө хэргийн оролцогчдоос нотлох баримт бүрдүүлэхтэй холбогдуулан санал, хүсэлт байгаа эсэхийг сайтар тодруулж асуух, өмгөөлүүлэх эрхийн талаар сайтар тайлбарлаж өгөх, өмгөөлөгч авах бол шүүх хуралдаанаас өмнө авч хэргийн материалтай танилцуулах талаарх ойлголтыг хэргийн оролцогч, зохигчдод тайлбарлаж өгөх шаардлагатай байна. Энэ оны хойшилсон нийт **58** шүүх хуралдаанаас өмгөөлөгчийн хурал давхцсан, эсхүл өмгөөлүүлэх эрхтэй холбогдуулан өмгөөлөгч авах хүсэлтээр тус тус хойшилж хойшилсон шүүх хуралдааны хамгийн их хувийг эзэлж байгааг шүүгчийн туслахууд анхаарч өмгөөлөгчийн шүүх хуралдаан давхцаж буй эсэх, оролцогчоос өмгөөлүүлэх эрхтэй холбоотой хүсэлт байгаа эсэхийг урьдчилан сайтар тодруулж, https:/live.shuukh.mn/ сайтаас шүүж харж шүүх хуралдааныг товлох шаардлагатай байна.



**Шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, шүүх хуралдааны тов, тоймыг тухай бүр цахим систем /www.live.shuukh.mn/-д байршуулж шүүхийн цахим хуудаст холбосон талаар:**

Шүүх хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, эрүүгийн шүүх хуралдааны товыг 7 хоног бүрийн пүрэв гаригт, иргэний шүүх хуралдааны товыг 7 хоног бүрийн баасан гарагт гаргаж шүүх хуралдааны товын самбар, шүүхийн цахим хуудас /facebook/, Live.shuukh.mn-д тухай бүр тус тус байршуулж хэргийн оролцогч болон иргэдэд мэдээлж, шүүх хуралдааны оролцогчдын тоо, багтаамж зэргийг харгалзан шүүх хуралдаан явуулах танхимын бэлтгэлийг ханган ажиллаж байна.












**/Live.shuukh.mn шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим системд эрүү, иргэн зөрчлийн шүүх хуралдааны явцыг тухай бүр хөтөлж буй байдал болон шүүх хуралдааны товыг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулсан байдал/**

**Хэргийн оролцогчийг зайнаас буюу цахимаар шүүх хуралдаанд оролцуулах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулсан талаарх ажиллагаа**

Тус шүүх нь “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам”-д заасны дагуу шүүх хуралдаанд цахимаар оролцох хүсэлт гаргасан хэргийн оролцогчоос 3 хоногийн өмнө цахим оролцогчийн баталгаа гаргуулан авч нийт **105** хэргийн оролцогчийг шүүх хуралдаанд зайнаас буюу цахимаар оролцууллаа. Үүнээс эрүүгийн хэрэгт **42** оролцогч, иргэний хэрэгт **47** зохигч, зөрчлийн хэрэгт **3** оролцогч, таслан сэргийлэх арга хэмжээний хуралд нийт **13** оролцогчийг цахим техникийн боломцоогоор хангаж “Zoom meeting” программ ашиглан тус тус оролцуулсан байна.





Тус шүүх нь шүүх хуралдааны 2 танхимтай бөгөөд шаардлагатай тоног төхөөрөмжөөр шүүх хуралдааны бэлтгэл ажлыг тухай бүр хангаж, шүүх хуралдааны хэвийн тасралтгүй явуулах нөхцөл боломцоог ханган ажиллаж байна.



**/Шүүх хуралдааны 1-р танхим/**



**/Шүүх хуралдааны 2-р танхим/**

Эрүүгийн шүүх хуралдааны товыг 7 хоног бүрийн пүрэв гарагт тус сум дахь сум дундын Прокурор газар, Цагдаагийн хэлтэст урьдчилан мэдэгдсэний дагуу цагдаагийн албан хаагчийг шүүх хуралдааны дэг сахиулагчаар байлцуулан шүүх хуралдааныг хэвийн явуулах нөхцөл, шүүгч, шүүх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг ханган ажилладаг.

Шүүх хуралдааны явцыг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга дуу, дүрс, бичлэгээр баталгаажуулан долоо хоног бүрийн баасан гарагт шүүхийн мэдээлэл технологийн мэргэжилтэнд хүлээлгэн өгч бүртгэл хөтлөн ажилласан.

2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 1,833 шүүх хуралдааны бичлэгийг хүлээлгэн өгч, шуурхай зөвлөгөөнд танилцуулж, архивласан байна.



ШҮҮХ ХУРАЛДААНЫ БИЧЛЭГ

2024.12.21-2025.11.19

Эрүү – 133 бүгд орсон

Цэдэнпэлжээ – 32
Болормаа – 101

Иргэн – 164 бүгд орсон

Цэдэнпэлжээ – 43
Болормаа – 121

Зөрчил – 1476 бүгд орсон

Цэдэнпэлжээ – 626
Болормаа – 850

Хойшилсон, буцаасан /захирамж/ - 33 бүгд орсон

Цэдэнпэлжээ-13
Болормаа – 20

Хойшилсон /шүүхийн тогтоол/ - 6

Цэдэнпэлжээ – 1
Болормаа – 5

Хянан магадлан /захирамж/ - 3 бүгд орсон

Цэдэнпэлжээ-1
Болормаа -2

Цагдан хорио – 18 бүгд орсон

Цэдэнпэлжээ - 3
Болормаа – 15

**/Шуурхай зөвлөгөөнд танилуулж буй байдал/**



**/ШХНБД нар МТМ-нд хүлээлгэж өгсөн бүртгэлийн дэвтэр/**





**/2025 оны диктафон болон камерын бичлэг бүхий хард диск/**

**Шүүхийн шийдвэрийг цахим хуудас /www.shuukh.mn/-т холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд байршуулж ажилласан талаар:**

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 39 тоот “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах” журам, 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 94 дугаартай “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолд заасан шүүхийн шийдвэрүүдийг тус журамд заасан холбогдох шаардлагыг хanган, цахим хуудаст байршуулж ажиллаж байна. 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар **shuukh.mn** шүүхийн шийдвэрийн цахим болон **court.zamin-uud.do.gov.mn** сайтад мэдээ, мэдээллийг доорх байдлаар байрлуулаад байна.

Shuukh.mn сайтад

1.Шүүхийн шийдвэр-**620**

2.Шийтгэх тогоол-**133** байршуулсан бөгөөд өөрийн шүүхийн цахим хуудаст Shuukh.mn сайтыг холбож, иргэдийг мэдээллээр хангаж ажиллаж байна.

**court.zamin-uud.do.gov.mn** сайтад шүүхийн шийдвэр болон процессын тойм 4, шүүх хуралдааны тов 32, шийдвэрлэсэн хэргийн тойм мэдээ 25, мэдээ мэдээлэл, тухайн шүүхээс олон нийтийг мэдээллээр хангах чиглэлээр явуулсан сургалт үйл ажиллагааны мэдээ 8-г тус тус байршуулаад байна.





*/court.zamin-uud.do.gov.mn сайтад мэдээ, мэдээлэл, шүүхийн шийдвэрийн тойм байршуулсан байдал/*



**Шүүхийн шийдвэр, шүүхийн мэдэгдэх хуудас, гүйцэтгэх хуудас, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл, эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэлийг холбогдох байгууллага, иргэнд тухай бүр хүргүүлсэн талаар:**

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар хуулийн хүчин төгөлдөр болсон 615 иргэний хэрэг, 101 эрүүгийн хэрэг, 549 зөрчлийн хэргийг тус тус архивд шилжүүлсэн байна.

| Архивд хэрэг, баримт хүлээн авсан байдал | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Эрүүгийн хэрэг | | Иргэний хэрэг | | Зөрчлийн хэрэг материал | | Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны материал | | Бусад баримт | |
| Нийт | Үүнээс тухайн 7 хоногт | Нийт | Үүнээс тухайн 7 хоногт | Нийт | Үүнээс тухайн 7 хоногт | Нийт | Үүнээс тухайн 7 хоногт | Нийт | Үүнээс тухайн 7 хоногт |
| 101 | 1 | 615 | 2 | 549 | 30 | 204 | - | 140 | - |

/Архивд хүлээн авсан мэдээг 7 хоног бүр шуурхай зөвлөгөөнд танилцуулж хэвшсэн байдал/

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх нь долоо хоног бүр давж заалдах, хяналтын шатны шүүхэд хянагдаж байгаа хэргийн судалгааг гаргаж шуурхай зөвлөгөөнд танилцуулж хэвшсэн бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хянагдаж байгаа эрүү, иргэн, зөрчлийн хэрэг дараах байдалтай байна.

| ДАВЖ ЗААЛДАХ, ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭД ХҮРГҮҮЛСЭН ХЭРГИЙН МЭДЭЭ | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| № | ДЗШШ-рүү | Эрүү | Иргэн | Зөрчил | ШШГА | Нийт |
| 1 | Э.Болормаа | 3 | | 1 | | 4 |
| 2 | Д.Цэдэнпэлжээ | | | | | |
| 3 | **Нийт** | 3 | | 1 | | 4 |
| № | ХШШ-рүү | Эрүү | Иргэн | | | |
| 1 | Э.Болормаа | 1 | 1 | | | 2 |
| 2 | Д.Цэдэнпэлжээ | | | | | |
| 3 | **Нийт** | 1 | 1 | | | 2 |

**Шүүхийн бичиг хүргэгчийн ажлын тоон мэдээллийн талаар:**

Тус шүүх бичиг хүргэгчийн бичиг хүргэлтийн мэдээ 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар дараах бичиг баримтуудыг хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан байна.







| № | Эрх зүйн акт | Нийт дүн | № | Эрх зүйн акт | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| Эрүү, зөрчил | Шийтгэвэр | 2874 | Иргэн | Шийдвэр | 43 |
| | Шийтгэх тогтоол | 145 | | Шүүгчийн захирамж | 98 |
| | Шүүгчийн захирамж | 27 | | Мэдэгдэх хуудас | 101 |
| | Албан тоот | 96 | | Албан тоот | 53 |
| | Шуудан | 503 | | Шуудан | 825 |
| | Шүүх хурлын тов | 51 | | Гүйцэтгэх хуудас | 733 |
| | Гүйцэтгэх хуудас | 433 | | Давж заалдах гомдол, бусад | 2 |
| | Давж заалдах гомдол | 24 | | Шүүхийн тогтоол | 2 |
| | Нийт | 4153 | | Нийт | 1857 |

Тус шүүхийн бичиг хүргэгч нь тайлант хугацаанд нийт 6010 бичгийг хуулийн хугацаанд хүргэж, хэргийн хөдөлгөөний аргачлалд заасны дагуу холбогдох бичиг хүргэгчийн бүртгэлийн дэвтрүүдийг хөтөлж ажилласан.


ГҮЙЦЭТГЭХ ХУУДАСНЫ ДУГААРЫН БҮРТГЭЛ №12

| д/д | Нэхэмжлэгч | Хариуцагч | Шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын огноо, дугаар | Төлбөрийн дүн, гүйцэтгэвэл зохих ажиллагаа | Гүйцэтгэх хуудас бичсэн шүүгчийн нэр | Гүйцэтгэх хуудсыг хүлээлгэн өгсөн огноо | Хүлээж авсан хүний гарын үсэг, нэр, явуулсан албан бичгийн огноо, дугаар | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

Тус шүүхээр хянан шийдвэрлэсэн 133 эрүүгийн хэргийн 168 хүний “эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”-ийг Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны статистик мэдээллийн хэлтсийн лавлагааны санд журамд заасан хугацаанд хүргүүлсэн.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХ

2025.11.14 № 765

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ЛАВЛАГААНЫ САНД

Тус шүүхээр шийтгэгдсэн Б.Дашням, Г.Нарангарав, Н.Чинзориг нарт эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэлийг хавсралтаар гаргаж хүргүүлэв.

Хавсралт 4 хуудастай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Э.БОЛОРМАА

1372251

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2025 оны 11 сарын 14-ний өдрийн 765 дугаар албан бичгийн хавсралт

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Б.Дашням | 2025.11.12-ны өдрийн 2025/ШЦТ/131 дугаартай | ЭХТА-ийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг | 252.0000.0001.30 |
| 2 | Г.Нарангарав | 2025.11.12-ны өдрийн 2025/ШЦТ/132 дугаартай | ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг | 252.0001.9001.17 |
| 3 | Н.Чинзориг | 2025.11.13-ны өдрийн 2025/ШЦТ/133 дугаартай | ЭХТА-ийн 27.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг | 232.0001.6600.03 |

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 71 дугаар тогтоолын 4-р хавсралт

ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭСЭН ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ ХҮРГҮҮЛСЭН БҮРТГЭЛ №7

| Д/д | Ялтны овог, нэр | Эрүүгийн хэргийн дугаар | Шийтгэх тогтоолын огноо, дугаар | Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалт, оногдуулсан ял, албадлагын арга хэмжээ | Албан бичгийн дугаар, огноо | Хаана хүргүүлсэн, хүлээн авсан албан тушаалтны овог нэр, гарын үсэг, огноо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 167 | Г.Нарангарав | 252.0001.9001.17 | 2025.11.12 2025/шцт/132 | ЭХТ-ийн 11.6-1 [illegible] | 2025.11.14 АТ-765 | [illegible] |
| 168 | Н.Чинзориг | 232.0001.6600.03 | 2025.11.13 2025/шцт/133 | ЭХТ-ийн 27.10-3 [illegible] | 2025.11.14 АТ-765 | [illegible] |

**/Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэлийг хүргүүлж ажилласан талаар/**

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт гүйцэтгэх хуудсыг хүргүүлсэн талаар:**

Эрүү, иргэн, зөрчлийн хэрэгт бичигдвэл зохих гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр, шийтгэх тогтоол, шийтгэвэр хүчин төгөлдөр болмогц бичиж, харьяалах шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлж ажиллаж байна. Иргэний хэрэгт шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг хүлээн авч, шүүгчийн захирамж гарснаас хойш 7 хоногийн дотор шүүгчийн захирамж, албадан гүйцэтгүүлэх хүсэлт холбогдох баримтыг гүйцэтгэх хуудасны хамт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бичиг хүргэгчээр хүргүүлэн ажиллалаа. Тайлант хугацаанд:




Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлээгүй гүйцэтгэх хуудас байхгүй бөгөөд хуулийн хүчин төгөлдөр болсон шийтгэх тогтоолд гүйцэтгэвэл зохих гүйцэтгэх хуудсыг бүрэн хүргүүлсэн болно.

**Шүүн таслах ажлын төрлөөр холбогдох мэдээллийг бүртгэл, хяналтын нэгдсэн системд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрээр цаг тухайд нь оруулж, бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлан мэдээ гаргах, хэргийн хөдөлгөөний нэгдсэн системийг шүүгч, шүүхийн захиргааны ажилтан ашиглах нөхцөлийг бүрдүүлэх**

Эрүүгийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, иргэн-2014 программуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрийг бүрэн гүйцэт хөтөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан эрх зүйн актуудыг системд бүрэн гүйцэт оруулж мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. Эрх зүйн актууд хугацаандаа системд бүрэн гүйцэт орсон эсэхэд 7 хоног бүр хяналт тавин ажиллалаа. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтан хэргийн хөдөлгөөний нэгдсэн мэдээллийг системээс бүрэн авч ашиглаж байна.

**Хавтас хэрэг илгээх, хүлээж авах журмын дагуу хэрэг, баримтыг шүүх хооронд илгээх, шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьсан талаар:**

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан “Хавтаст хэрэг илгээх, хүлээн авах” журмын хүрээнд тус шүүхийн тамгын газрын даргын тушаалаар шүүхийн хавтас хэрэг илгээх, хүлээн авах ажилтанг томилон ажилласан.

Хавтаст хэрэг илгээх, түүнийг хүлээн авах журмын дагуу эрүү, иргэн, зөрчлийн нийт 47 хэргийг богцоор Давж заалдах болон Хяналтын шатны шүүхэд хүргүүлсэн. Шүүхийн бичиг хүргэгчээр /эрүү, иргэн, зөрчлийн хэргийн эрх зүйн актууд, болон шүүхийн тамгын газар/-аас нийт 1392 албан бичгийг аж, ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэнд хүргүүлсэн. Энэ хугацаанд богцны хэвийн байдал болон шуудан харилцааны үйл ажиллагаа хэвийн, ямар нэгэн зөрчилгүй ажиллалаа.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2024 оны 07 сарын 01-ний өдрийн 01/1181 тоот албан бичгийн дагуу тус сум дахь “Монгол шуудан”-гийн салбартай гэрээ байгуулан албан бичиг, хавтаст хэргийг холбогдох газарт нь хүргүүлж байна.


ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

АНХАН БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ

ДАРГА


МОНГОЛ ШУУДАН

МОНГОЛ ШУУДАН ХК

ГЭРЭЭТ БАЙГУУЛЛАГУУДАД

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Хавсралт: /Гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны А/118 тоот/

БИЗНЕС ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭНХ-АМГАЛАН

Мөн Эрүү, иргэн, зөрчлийн нийт 66 хэрэгт 66 удаа хэрэг хүлээлцсэн баримт үйлдэж, 47 удаа богцоор хэрэг явуулж, 53 удаа зохих журмын дагуу богцоор хэрэг хүлээн авсан.





ХЭРЭГ ХҮЛЭЭЛЦСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 10 сарын 10 өдөр Дугаар 66 Замын-Үүд сум

Тэмдэглэл:

Хүлээлгэн өгсөн:

Хүлээн авсан:

20.. оны ... сарын ... ны өдөр хүлээн авсан

## Холбогдох хууль, дүрэм, журмын төсөлд санал хүргүүлэв.

Шинээр батлагдах хууль, дүрэм, журмын төсөлд санал, шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан ирүүлсэн албан бичиг, төслийг нийт шүүгч, ажилтнуудад танилцуулж, саналыг нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

| № | Он сар | Ирүүлсэн байгууллага | Товч утга | Явуулсан бичиг он, сар, өдөр, дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | 2025.01.27 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд буцалтгүй тусламж олгох журмын төсөлд санал авах тухай | 2025.02.03-ны өдрийн 58 дугаартай албан бичиг |
| 2 | 2025.01.28 | Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх тусгай архив | Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтын нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд санал авах тухай | 2025.02.10-ны өдрийн 63 дугаартай албан бичиг |
| 3 | 2025.01.30 | Шүүхийн Ерөнхий зөвлөл | Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх таслан зогсооход чиглэсэн хууль эрх зүйн орчныг сайжруулах талаар санал ирүүлэх тухай | 2025.02.10-ний 64 дугаартай албан бичиг |
| 4 | 2025.03.11 | Шүүхийн Ерөнхий Зөвлөл | Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах тухай | 2025.03.17-ны өдрийн 85 дугаартай албан бичиг |
| 5 | 2025.04.03 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглээх журам шинэчлэн батлах тухай засгийн газрын тогтоолын төсөлд санал авах тухай | 2025.04.07-ны өдрийн 127 дугаартай албан бичиг |
| 6 | 2025.04.17 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах тухай | 2025.04.25-ны өдрийн 143 дугаартай албан бичиг |
| 7 | 2025.05.01 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авах тухай | 2025.05.09-ний өдрийн 156 дугаартай албан бичиг |
| 8 | 2025.05.13 | Шүүхийн академи | Нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудаст байршуулах журмын хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлын талаар санал авах тухай | 2025.05.19-ний өдрийн 162 дугаартай албан бичиг |
| 9 | 2025.05.16 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуулийн төсөлд санал авах тухай | 2025.05.22-ны өдрийн 172 дугаартай албан бичиг |
| 10 | 2025.06.05 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангах хөтөлбөрийн төсөл болон шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буй цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд санал авах тухай | 2025.06.10-ны өдрийн 188 дугаартай албан бичиг |
| 11 | 2025.06.13 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд санал авах тухай | 2025.06.25-ны өдрийн 200 дугаартай албан бичиг |
| 12 | 2025.08.14 | Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дэргэдэх шүүхийн тусгай архив | Баримт бичиг MNS5140:2021 стандартад нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд сансал авах тухай | 2025.08.20-ны өдрийн 236 дугаартай албан бичиг |
| 13 | 2025.09.17 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Гэр бүлийн шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд санал авах тухай | 2025.09.24-ний өдрийн 289 дугаартай албан бичиг |
| 14 | 2025.09.23 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Шүүхийн захиргааны байгууллагын ажилтны ажил хэргийн ур чадвар мэргэшлийн түвшинг үнэлэх журмын төсөлд санал авах тухай | 2025.09.30-ны өдрийн 299 дугаартай албан бичиг |
| 15 | 2025.10.13 | Шүүхийн ерөнхий зөвлөл | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон бусад хуулийн төсөлд санал авах тухай | 2025.10.20-ны өдрийн 328 дугаартай албан бичиг |
| 16 | 2025.10.24 | Монгол улсын дээд шүүх | Эрүүгийн хэргийн шүүхийн практик 2025 хэлэлцүүлэгт хэлэлцэх асуудлын талаар санал авах тухай | 2025.10.30-ны өдрийн 354 дугаартай албан бичиг |
| 17 | 2025.11.10 | Шүүхийн Ерөнхий зөвлөл | Шүүхэд албан хэрэг хөтлөх журмын төсөлд санал авах тухай | 2025.11.12-ны өдрийн 373 дугаартай албан бичиг |

**Эрүү, зөрчлийн хэрэгт хүлээн авсан эд мөрийн баримтуудыг устгах ажил зохион байгуулсан талаар:**

Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн №246, А/80 захирамж, тушаалын дагуу "Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам"-ын дагуу шүүхийн тамгын газрын даргын 2024 оны 12 сарын 05-ны өдрийн Б/32, 2025 оны 09 сарын 08-ны өдрийн А/33 дугаартай тушаалаар эд мөрийн баримт хүлээж авах 1 шүүгчээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй эд мөрийн баримт хүлээн авах, устгах комиссыг шинэчлэн томилж, прокурорын байгууллагаас шилжиж ирсэн хэргийн эд мөрийн баримтыг холбогдох журамд нийцүүлэн шалган хүлээн авч байна.





Тус шүүхийн тамгын газрын эд мөрийн баримт хүлээн авах комисс нь эрүүгийн хэрэгт хүлээн авсан эд мөрийн баримтуудыг тухай бүр яллах дүгнэлт болон, мөрдөгчийн шийдвэр, эд мөрийн баримтаар тооцсон тогтоолтой тохирч байгаа эсэхийг шалган хүлээн авдаг. Тус шүүхийн эд мөрийн баримтын комисс 2025 онд 33 хэргийн эд мөрийн баримтыг зохих журмын дагуу хүлээн авч, эд мөрийн баримт хүлээн авсан тэмдэглэлийг үйлдэн комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан 1 хувийг хэрэгт 1 хувийг хуулгад хавсарган хадгалж байна. Мөн прокурорын байгууллагаас ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системээр хүлээн авахдаа программын бүртгэлийг шалган, эд мөрийн баримтаар тооцсон тогтоолтой тааруулан бүртгэж хүлээн авч байна.





2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар эрүүгийн 33 хэргийн эд мөрийн баримтыг шинээр хүлээн авсан бөгөөд тус шүүхийн эд мөрийн баримт хүлээн авах, устгах комисс нь 2025 оны 01 дүгээр сарын 22, 2025 оны 09 сарын 11-ний өдрүүдийн хуралдаанаар шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон 19 хэргийн эд мөрийн баримтыг устгахаар шийдвэрлэж, зохих журмын дагуу устгах ажлыг зохион байгуулсан. Шийтгэх тогтоолоор түүх соёлын дурсгалт зүйлийг холбогдох байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2 хэргийн эд мөрийн баримтыг Дорноговь аймгийн музейд хүлээлгэн өгсөн байна.




**/Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах 12 болон 82 дэс дугаар бүхий эд мөрийн баримтыг хүлээлгэн өгч буй байдал/**




**/Нэг удаагийн нийлэг хальсан уут болох эд мөрийн баримтыг холбогдох газраар устгалд оруулж буй байдал/**




**/Нэр бүхий 18 эд мөрийн баримтыг устгаж буй байдал/**

## 1.2.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог хангасан байдал

Тус шүүхийн тамгын газарт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн жагсаалтын дагуу шүүхийн тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/22 тоот тушаалаар “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам”-д зааснаар 244 шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийг баталсан. 2025 онд иргэдийн төлөөлөгч оролцуулах шүүх хуралдаан бүрд Иргэдийн төлөөлөгчийн программаас сонгогдсон иргэдийн төлөөлөгчдийн нэрсийн дэд жагсаалтыг тамгын газрын даргын тушаалаар баталж, нийт **9** иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулсан.



Дэд жагсаалт батлах тухай

[illegible]

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ШҮҮГЧИЙН ТУСЛАХ



ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧӨӨР ОРОЛЦОХ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН НЭРС

| № | Овог | Нэр | Хаяг | Утасны дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 2 | [illegible] | [illegible] | [illegible] | |
| 3 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 4 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 5 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 6 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 7 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 8 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 9 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 10 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцооны мэдээг 2025 оны 1-р улирал, хагас жил, 3 улирлаар гаргаж мэдээг e-case системд оруулж байгууллагын сайтад байршуулсан.







Харьяалах сумдын иргэдийн төлөөлөгч нарт гарын авлага тараaж, шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох журмын талаар танилцуулж, мэдээлэл өгч ажиллалаа.





## 1.3. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа

**Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Ерөнхий зөвлөл болон Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан дүрэм, журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажилласан талаар:**

Тус шүүхэд эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах гэсэн 2 орон тоотойгоор шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Шүүхийн Ерөнхий зөвлөл болон Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан дүрэм, журамд заасны дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх дэх Эвлэрүүлэн зуучлал нь 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар өмнөх оны үлдэгдэл 11, өргөдөл шинээр хүлээн авсан 250 бөгөөд шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлсэн хэрэг 2 байна. Эвлэрүүлэн зуучлалд хандсан өргөдлийн маргааны төрлөөр ангилан үзвэл иргэний эрх зүйн маргаан 167, гэр бүлийн маргаан 76, шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн 2 хэрэг байна. Эвлэрүүлэн зуучлагч нь тухайн онд:






**Шүүхийн ачаалал бууруулсан байдал:**

| Д/д | Он | Шийдвэрлэсэн нийт иргэний хэрэг | Үүнээс | | Эвлэрүүлэн зуучлалаар амжилттай шийдвэрлэсэн өргөдөл | Шүүхийн ачааллын бууруулсан байдал /хувиар тооцов/ | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хялбаршуулсан журмаар | Шүүх хуралдаанаар | | Нийт хэргийн хувьд | Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэргийн хувьд |
| 1 | 2024 | 281 | 157 | 124 | 76 | 27.04 | 48.4 |
| 2 | 2025 | 675 | 527 | 148 | 160 | 23.7 | 30.3 |

Тайлант хугацаанд Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх нь 844 нэхэмжлэл хүлээн авсан бол тус шүүх дэх эвлэрүүлэн зуучлал 250 өргөдөл хүлээн авсан. Үүнээс үзэхэд тус шүүхийн иргэний хэргийн ачааллыг 29.6 хувиар бууруулан ажилласан байна.

Тус эвлэрүүлэн зуучлал нь 2024 онд улсын тэмдэгтийн хураамж 3,173,630 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж байсан бол 2025 онд улсын тэмдэгтийн хураамж 6,513,045 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

**Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны мэдээ, судалгаа, тайлан гаргах, тайлагнах**

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны 7 хоног бүрийн мэдээг гарган Даваа гарагийн шуурхай зөвлөгөөн дээр танилцуулан ажиллаж байна.

**Эвлэрүүлэн зуучлалын мэдээ**

2024.12.21-2025.11.19 Замын-Үүд сум

| Тайлангийн үлдэгдэл | Хүлээж авсан өргөдөл | | Нийт өргөдөл | Үүнээс тухайн 7 хоногт хүлээж авсан | Шийдвэрлэсэн | | | | Эвлэрүүлэн зуучлал хэрэглэхээс татгалзсан | | | | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эвлэрүүлэн зуучлалд хандсан | Шүүхээс шилжүүлсэн | | | Амжилттай | Тухайн 7 хоногт | Амжилтгүй /дуусгавар болсон/ | Тухайн 7 хоногт | Хүлээн авахаас татгалзсан | Тухайн 7 хоногт | Өргөдөл гаргагч өргөдлөө татан авсан | Тухайн 7 хоногт | |
| 11 | 248 | 2 | 261 | - | 160 | 3 | 62 | - | 9 | - | 17 | - | 13 |

/7 хоног бүрийн шуурхай зөвлөгөөний эвлэрүүлэн зуучлалын мэдээ/

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны 1, 2, 3 дугаар улирлын болон хагас жилийн мэдээ тайланг хугацаанд нь гарган хүргүүлсэн байна.







**Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн ажиллах нөхцөлийг хангах, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх**

Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн 2013 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Ажлын байрны стандарт батлах” тухай тогтоолын дагуу эвлэрүүлэн зуучлах өрөө нь 12 метр квадрат талбайгаас доошгүй хэмжээтэй, эвлэрүүлэн зуучлагч уулзалтын тусгай өрөөтэй, уулзалтын ширээ нь ирмэггүй зууван байх, зуучлагчийн туслахын өрөө нь үүдэн талдаа байх, уужуу саруул цонхтой, зохих стандартын шаардлага хангасан байна гэж заасан. Уг шаардлагад заасан уулзалтын тусгай өрөөгүй боловч бусад нөхцөл байдлуудыг өөрсдийн боломж бололцоонд тулгуурлан засаж сайжруулан ажиллах нөхцөл бололцоогоор ханган ажиллаж байна.



## 1.4.Шүүхийн мэдээллийн технологийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

Шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд шүүхийн программ хангамж ашиглах, нөхцөлийг бүрдүүлж тухай бүрд нь шаардлагатай засвар үйлчилгээ, мэдээллээр хангаж ажилласан. Шүүхийн мэдээлэл технологийн аюулгүй байдалтай холбогдох журам, заавар стандартын дагуу шүүгч, шүүхийн захиргааны ажилчдад мэдээлэл хүргэж анхаарвал зохих зүйлсийг сануулж ажилласан.

2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 1,928 шүүх хуралдааны бичлэг хүлээлгэн өгч бүртгэл хөтөлснөөс эрүүгийн хэргийн 133, иргэний хэргийн 195, зөрчлийн хэргийн 1,540, таслан сэргийлэх арга хэмжээний 18 шүүх хуралдааны бичлэгийг хүлээлгэн өгч, архивласан байна.



**/2025 оны камерын бичлэг бүхий хард диск/**

Шүүхийн компьютер, хувилагч, хэвлэгч, хяналтын дотоод, гадаад камер болон бусад тоног төхөөрөмж, интернэт, сүлжээний хэвийн байдал, тасралтгүй ажиллагааг хангаж бүртгэл хийж засвар үйлчилгээг тухай бүр нь хийж гүйцэтгэж ажилласан.



ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ БҮРТГЭЛ

2025 он

| № | Эзэмшигч /Өрөөний дугаар/ | Албан тушаал | Гарсан алдаа /Огноо/ | Хийгдсэн ажиллагаа /Огноо/ | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 2 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 3 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 4 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 5 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 6 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 7 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 8 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 9 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 10 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 11 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 12 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 13 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 14 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 15 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 16 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

Иргэн-2014, эвлэрүүлэн зуучлалын систем, эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем, шүүх хуралдааны явцын мэдээлэх цахим систем **live.shuukh.mn**, хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем **case.shuukh.mn**, шүүхийн цахим мэдээллийн сан **shuukh.mn**-н аюулгүй байдал, систем ашиглах зөвлөмж гарын авлагыг танилцуулж, алба хаагчдын ашиглалтад хяналт тавьж хэрэгтэй мэдээллийг хүргэж ажилласан.

2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хүртэл иргэдийн төлөөлөгчийн программаас тус шүүхийн тамгын газрын даргын тушаалаар иргэний 2, эрүүгийн 7, нийт 9 бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг баталж шүүх хуралдаанд оролцуулсан.



Шүүх хуралдааны үед нотлох баримт шинжлэн судлах төхөөрөмж ашиглан хэрэгт авагдсан нотлох баримтуудыг шинжлэн судалж байна.





**/Нотлох баримт шинжлэн судалж буй байдал/**

Тус шүүхэд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн вирусийн программ, алдаа шалгах “Болор дуран” программыг шүүх, шүүхийн захиргааны ажилтнуудын компьютерт суулгаж мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Мөн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар “чимэгэ бичээч” программыг ашиглан шүүх хуралдааны тэмдэглэлийг бичиж байна.







Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс тус шүүхэд шүүх хуралдааныг шууд дамжуулах төхөөрөмж буюу **YOLOBOX**-г суурилуулсан ба авлига албан тушаалын хэргийн 5 шүүх хуралдааныг шууд дамжуулан ажилласан байна.






## 1.5.Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

| Д/д | Нэр | Тоо | Хаанаас | Утга |
|---|---|---|---|---|
| **Ирсэн бичиг** | | | | |
| 1 | Шийдвэрлэсэн | 6 | 1.Шүүхийн академи<br>2.Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх<br>3.Баянзүрх дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэс<br>4.Шүүхийн Ерөнхий зөвлөл<br>5.Шүүхийн Ерөнхий зөвлөл<br>6. Шүүхийн Ерөнхий зөвлөл | 1. Судалгааны эх сурвалж ирүүлэх тухай /2025.01.01-2025.07.01-нийг хүртэлх хугацаанд шүүх хуралдааныг хойшлуулсан шүүгчийн захирамжийг ирүүлэх тухай/<br>2.Ц.Анхжаргал, Д.Батхүү, Ц.Зоригтбаатар, Ц.Анужин, А.Болор-Эрдэнэ, А.Баярбаатар, У.Шинэбаяр, Г.Эрдэнэчимэг, Б.Цэрэндулам нарын оршин суугаа хаягийн лавлагааг гаргаж ирүүлэх тухай<br>3.Б.Гансүхэд холбогдох шийтгэх тогтоолын хуулбар авах тухай<br>4. 2019-2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар Төрийн албаны тухай хуулиар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр ирүүлэх тухай<br>5. Иргэдийн төлөөлөгчдийн нэрсийг тамгын газрын даргын тушаалаар баталгаажуулж ирүүлэх тухай<br>6.“Шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх журам”-ын 6.2.3-т “...шалгуур үзүүлэлт бүхий хүснэгтийн дагуу гаргаж ирүүлэх тухай |
| 2 | Хариугүй | 1 | 1.Дорноговь аймгийн засаг дарга | 1. Нягтлан бодогч нарыг чадавхжуулах сургалтад хамруулах тухай |
| 3 | Хяналтад байгаа | 2 | 1.Шүүхийн ерөнхий зөвлөл<br>2.Шүүхийн ерөнхий зөвлөл | 1.Тамгын газрын үйл ажиллагааны тайлан ирүүлэх тухай /2025.12.01/<br>2.Чиглэл хүргүүлэх тухай/ Шүүхийн үйл ажиллагаанд аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж тайлан ирүүлэх /2025.12.15/ |
| 4 | Хугацаа хэтэрсэн | - | | |

**Тамгын газарт хандан гаргасан өргөдөл, хүсэлт**

| Хэнээс | Утга | Шийдвэрлэсэн эсэх |
|---|---|---|
| Иргэн Б.Шинэбаяр | Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусаагүй байгаа талаар тодорхойлолт авах тухай | Тодорхойлолтыг хүргүүлсэн. |

**Явуулсан бичиг**

| | | | |
|---|---|---|---|
| 5 | 5 | 1.Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар<br>2.Замын-Үүд сумын Засаг дарга<br>3.Шүүхийн Ерөнхий зөвлөл<br>4.Шүүхийн Ерөнхий зөвлөл<br>5.Шүүхийн Ерөнхий зөвлөл | 1.Шүүхийн албаны машин дээр БНХАУ-руу гарах зөвшөөрөл гаргуулах тухай<br>2.Нярав М.Мөнхсайханы шагналын материал хүргүүлэх тухай<br>3.2026 оны төсөвт шинжээчийн зардлыг нэмүүлэх тухай<br>4.Цахим хүсэлт хүргүүлэх тухай. /шүүхийн нэрийг засуулах тухай/<br>5.Цахим хүсэлт хүргүүлэх тухай /Хоосон баталгаажуулсан эрх зүйн актыг баталгаажилтыг авхуулах тухай/ |

**/Шуурхай зөвлөгөөнд танилцуулдаг тамгын газарт ирсэн болон явуулсан бичгийн мэдээг 1 долоо хоногоор хүснэгтээр харуулав/**

**Захидал харилцаа, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам, заврын дагуу зохион байгуулах**

2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн байдлаар шүүхийн тамгын газарт 468 ирсэн бичгийг хүлээн авч 394 албан бичгийг явуулсан байна. Тус шүүхийн тамгын газарт ирсэн 468 албан бичгийн 206 нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс, 37 нь Монгол Улсын Дээд шүүхээс, 225 нь бусад байгууллагаас тус тус ирсэн байна. Албан бичгүүдэд тухай бүр нь хариуг хүргүүлж ажиллалаа. Шүүхийн тамгын газарт ирсэн албан бичгүүдийг ангилж үзвэл дараах байдалтай байна.




Шүүхийн тамгын газраас явуулсан албан бичгүүдийг ангилж үзвэл дараах байдалтай байна.



**Архивд хадгалбал зохих хэрэг, баримт бичгийг хүлээн авах, данс бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулж, баримт нягтлан шалгах орон тооны бус комиссыг Тамгын газрын дэргэд байгуулж ажиллуулсан талаар:**

Шүүхийн архивын хадгаламжийн санд өнөөдрийн байдлаар нийт 6874 ширхэг хадгаламжийн нэгж байгаагаас иргэний хэрэг 3036, эрүүгийн хэрэг 93, зөрчлийн хэрэг 552, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны материал 1895, бусад баримт 1298 хадгалагдаж байна. Тус шүүхийн архивд 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 2025 онд хянан шийдвэрлэсэн 101 эрүүгийн хэрэг, 615 иргэний хэрэг, 549 зөрчлийн материал, 204 эвлэрүүлэн зуучлалын материал, бусад 140 баримт хүлээн авч, бүртгэлд оруулан, хадгаламжийн нэгж үүсгэн архивласан байна.




**/Хадгаламжийн сангийн өрөөнд, нягтаршуулсан шүүгээ, галын аюулгүй байдлын зөвлөмж болон галын хор, багаж хэрэгсэл, чийг дулаан хэмжигч байршуулсан байдал/**

Тус шүүх нь 2024 онд шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 192, зөрчлийн хэрэг 525-ийг төрийн архивд шилжүүлжээ. Үүнээс Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх Эрүүгийн хэргийн төв архивд байнга хадгалах эрүүгийн 10 хэрэг, Дорноговь аймгийн Прокурорын газрын архивд түр хадгалах эрүүгийн 182 хэрэг, зөрчлийн хэргийн 525 материалыг 2025 оны 1 дүгээр улиралд шилжүүлсэн байна. Тус шүүхийн номын сан 89 нэр төрлийн ном товхимол сэтгүүлтэй бөгөөд, Шүүхийн ерөнхий зөвлөл болон бусад байгууллагаас ирсэн Төрийн мэдээлэл, бусад сэтгүүл зэргийг байршуулан шүүгч, албан хаагчдыг уншиж, танилцах боломжоор хангасан.

**Архивын хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлж буй талаар:**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор шүүхийн архивын хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлэх тухай журмыг баталж цаасан суурьтай архивд хадгалагдаж буй хэрэг, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны материал, шүүхийн эрх зүйн акт, тамгын газрын удирдлага зохион байгуулалттай холбоотой баримт бичгүүд, санхүүгийн баримтууд зэргийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус шүүхийн архив нь нийт 6874 хадгаламжийн нэгжтэй бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 19-ний байдлаар 4826 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлсэн.

2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Дорноговь аймгийн Өргөн, Эрдэнэ сумуудад ажилласан сургалтаар тус шүүхийн архивч нь “Шүүхийн архивын үйлчилгээний журам болон шүүхийн архиваас хэрхэн лавлагаа, хуулбар авах талаарх зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.



**/Мэдээлэл өгч, сургалт зохион байгуулж буй байдал/**



**/Шүүхийн архивын үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй хүргэж ажиллах үүднээс “Шүүхийн архивын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг тус танхимд байршуулсан байдал/**

"Шүүхийн архивын ажиллах журам"-ын хэрэгжилтэд шүүхийн тамгын газрын дарга өдөр тутамдаа хяналт тавин ажиллаж байна. Шүүхийн тамгын газрын дарга архивын хадгалалт, хамгаалалт, ашиглалтын талаар тогтмол шалгаж архивын ажилтанд үүрэг даалгавар, зөвлөмж өгч ажилладаг. Архивын хадгаламжийн нэгжийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж, хайлтыг зохион байгуулах зорилгоор тоо бүртгэлийг биет болон цахим хэлбэрээр бүрэн хөтөлж ажиллаж байна.

Шүүхийн архивын ажиллах журмын дагуу 2025 онд лавлагаа болон бусад баримт олгосон байдал:

- Аж, ахуйн нэгж байгууллагад 113
- Иргэнд 66 удаагийн лавлагаа олгож нийт 187,600 төгрөгийн архивын орлого бүрдүүлсэн байна.

Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ, үйлчилгээг 50 удаа, хадгаламжийн сангийн дулаан, чийглэгийн хэмжээг 87 удаа шалгаж тэмдэглэл үйлдсэн байна.

**Шүүгч, ажилтныг холбогдох байгууллагад шагналд тодорхойлсон талаар:**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тамгын газраас Төрийн болон салбарын, аймаг, сумын шагналд болзол хангасан шүүгч, ажилтныг хамт олны нэгдсэн хурлаар хэлэлцэж, тодорхойлон холбогдох байгууллагад материалыг хүргүүлж, дараах шагналаар шагнагдлаа.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн  Эвлэрүүлэн зуучлагч С.Баяржаргал нь эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гарган, үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлэн Хууль зүй, дотоод хэргийн яамны "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр, шүүгчийн туслах О.Уламмандах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга М.Энхцэцэг нарыг эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гарган, үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлэн Хууль зүй, дотоод хэргийн яамны "ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ"-ээр шагнуулсныг тус шүүхийн Ерөнхий шүүгч Д.Цэдэнпэлжээ  2025 оны 03 дугаар сарын 11-ний өдөр гардуулан өглөө.





**/Шүүхийн захиргааны ажилтнууд салбарын шагналаар шагнагдлаа/**

## 1.6.Шүүхийн бие даасан байдлыг хангах талаарх бусад үйл ажиллагаа

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж ажиллахад тус шүүхийн тамгын газар онцгой анхаарч ажиллаж байна. Тус шүүх нь хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зориулалтын налуу шат бүхий орох гарах орц, шүүхийн мэдээлэл лавлагааны мэргэжилтэн болон шүүгчийн туслахыг дуудах хонх, хараагүй бэрхшээлтэй иргэдэд зориулсан харааны шил, томсгогч шил, чихэвч, барелль үсгэн нэхэмжлэлийн загвар, тэргэнцэртэй иргэд үйлчлүүлэх зориулалтын ширээ, тэргэнцэр зэргийг байршуулсан хэсгийг тохижуулан ажиллаад 4 жил болж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус шүүхээр үйлчлүүлэх нөхцөл боломж бүрэн бүрдсэн.






**/Иргэн өөртөө үйлчлэх танхимын тусгай хэрэгцээт иргэдийн хэсэг/**

Мөн шүүхээр үйлчлүүлэгч иргэдэд шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх, шүүхээр үйлчлүүлэгч иргэдийн аюулгүй байдлыг хангах, шүүхийн байрны үйлчилгээний орчны хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч шүүхийн байрыг боломжит нөхцөлөөр хангаж ажиллаж байна.



**/Тус шүүхийн нээлттэй шүүх танхимын хэсэг/**

Тус шүүхэд зарлагдсан шүүх хуралдаанд оролцож байгаа иргэдэд шүүхийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах үүднээс “**Шүүхийн ногоон танхим**”-ыг тохижуулсан. Тус танхимд шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх, удаан үргэлжилсэн шүүх хуралдаан түр завсарлах, өмнөх шүүх хуралдаан дуусаагүй хүлээгдэх үед хэргийн оролцогчид байрлах боломжтой юм. Мөн тус танхимд иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулсан гарын авлага, ном товхимол зэргийг байршуулсан.




**/Шүүхийн хүлээлгийн ногоон танхимыг тохижуулсан байдал/**

Шүүгч, шүүх бүрэлдэхүүний хэрэгцээ шаардлагыг тухай бүр тодруулж, холбогдох хууль тогтоомжийн эмхэтгэл, толь бичиг, хуулийн тайлбар, дүрэм, журам, ном товхимол, судалгаа шинжилгээний материалыг авч өгөн, тавилга, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж ажилласан. Мөн шүүхийн “номын сан”-г шинээр гарсан хууль тогтоомж, онол, практик, эрдэм шинжилгээний ном, сэтгүүл, хуулийн тайлбар зэргээр баяжуулан ажиллаж байна.




**/Тус шүүхийн шүүгчдийн зөвлөлдөх тасалгаа/**



/Шүүхийн номын сангийн байдлыг харуулав/

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу ёс зүйн дэд хороог 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байгаа бөгөөд ёс зүйн дэд хорооны мэдээллийн самбарт мэдээ, мэдээллийг байршуулан иргэд, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.




/Ёс зүйн дэд хорооны мэдээллийн самбарт мэдээ, мэдээлэл байршуулсан байдал/

## 1.7. ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд нийт 75 ажил хийж хэрэгжүүлэхээр тусгасан ба Шүүхийн бие даасан байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний чиглэлээр төлөвлөгдсөн ажлууд 90 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн гэж дүгнэж байна.

Шүүхийн цахим хуудаснаас иргэд богино хугацаанд өөрт хэрэгтэй мэдээ, мэдээлэл, судалгаа, тайлан, цаг үеийн мэдээллийг авах боломжоор хангах, дээд шатны байгууллагын бодлого, хэрэгжүүлж байгаа ажлын талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд түгээн цахим хуудсыг эмх цэгцтэй хөтөлж, хөгжүүлэлтийг сайжруулж ажиллалаа. 2025 онд тус шүүхийн Тамгын газарт иргэн, хуулийн этгээд, албан байгууллагаас нийт 468 албан бичиг ирснээс 217 бичиг нь хариугүй, 251 бичиг нь хариутай ирсэн ба албан бичгийн хариуг тухай бүр хугацаанд нь явуулсан. Мөн тамгын газраас нийт 269 албан бичиг иргэн, байгууллагад 2025 оны 11 сарын 19-ний өдрийн байдлаар аль болох хүндрэлгүй, хүртээмжтэй хэлбэрээр зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.

Тус шүүхийн тамгын газар нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийн судалгааг хөтөч, туслахаар дамжуулан тогтмол авч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж ажилладаг бөгөөд сүүлийн жилүүдэд шүүхэд итгэх иргэдийн итгэл өссөн байгаа нь дээрх үйл ажиллагаануудын үр дүн юм.

## ШҮҮХИЙГ ХҮНИЙ НӨӨЦӨӨР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

### 2.1.Шүүхийн хүний нөөцийг бүрдүүлэх, сул орон тоог тухай бүр нөхөх, хүний нөөцийн программ ашиглалтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх, шүүхийн тамгын газар нь батлагдсан бүтэц, орон тооны дагуу 24 орон тоотойгоор ажиллахаас 20 хүний орон тооны хэлбэлзэлтэй ажиллаж байгаа боловч шүүхийн захиргаа удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн зохистой бодлогоор шүүхийн захиргааны ажилтнуудын ажил үүргийг жигд хуваарилах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд анхаарч ажиллалаа.

Шүүхийн тамгын газрын хувьд Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, шүүгчийн туслах 1, шүүгчийн туслах-3, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-2, мэдээлэл технологийн мэргэжилтэн-1, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн-1, эвлэрүүлэн зуучлагч-1, эвлэрүүлэн зуучлагчийн туслах-1, нягтлан-1, нярав-1, жолооч-1, үйлчлэгч-2, сантехникч-1, архивч-1, бичиг хэргийн эрхлэгч-1, бичиг хүргэгч-1 нийт 19 хүний оронтойгоор ажиллаж байна. 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар шүүгчийн туслахийн түр орон тоон дээр 1 албан хаагч ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 60 дугаартай зарлигаар хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрч шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шүүгч Дашзэвэгийн Цэдэнпэлжээд хүндэтгэл үзүүлж, "Хүндэтгэлийн шүүх хуралдаан" зохион байгууллаа.





Энэхүү хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Х.Үүрцайх, ахмад шүүгч Б.Сумъяа нар оролцлоо.

Тайлант хугацаанд тус шүүх нь 1 шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хүний нөөцийн программаас хасалтыг хийсэн байна.




Шүүгчийн 0, ажилтны 28 чөлөөний хүсэлтийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг бүртгэж, зэрэг дэв олгосон шийдвэрийн талаар 2, бусад нэмэгдэл 1, ээлжийн амралтын 18 боловсрол, сургалтын мэдээлэл 2 мэдээлэл оруулсан байна.

**Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлт**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тамгын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/18 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг шүүхийн хүний нөөцийн цаасан баримт бичиг болон цахим программын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийлээ.



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийх тухай

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ШҮҮГЧИЙН ТУСЛАХ Э.НАРАНТУЯА



ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ УДИРДАМЖ

2025.05.22

| дд | Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх | Хариуцан хийх хүний нэр |
|---|---|---|
| 1. | ШЕЗ-ээс баталсан орон тооны дагуу шүүхийн хүний нөөцийг бүрдүүлэх, мэдээллийн сан хөтлөх | Ажлын хэсэг А.Одончимэг |
| 2. | Шүүхийн хүний нөөцийн програм ашиглах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах | Ажлын хэсэг М.Юмчиндулам Ц.Энхзаяа |
| 3. | Төрийн албан хаагчийн хүний нөөцийн програм ашиглах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах | Ажлын хэсэг А.Одончимэг |
| 3. | Төрийн албан хаагчийн хувийн хэргийг холбогдох журмын дагуу хөтөлж байгаа эсэх | Ажлын хэсэг М.Юмчиндулам |
| 4. | Иргэдийн төлөөлөгчид зориулсан сургалтыг зохион байгуулсан талаар | Ажлын хэсэг Ц.Энхзаяа |
| 5. | Шүүгч,Шүүхийн захиргааны ажилтнуудад чөлөө олгосон байдал холбогдох хууль журмын заасны дагуу шийдвэрлэж буй байдал | Ажлын хэсэг Ц.Энхзаяа |
| 6. | Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг албан томилолтоор ажиллуулсан байдлын судалгаа | Ажлын хэсэг А.Одончимэг |

Төлөвлөгөө боловсруулсан
Ажлын хэсгийн ахлагч А.Одончимэг

**Шүүгч, ажилтныг холбогдох байгууллагад шагналд тодорхойлсон талаар:**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тамгын газраас Төрийн болон салбарын, аймаг, сумын шагналд болзол хангасан шүүгч, ажилтныг хамт олны нэгдсэн хурлаар хэлэлцэж, тодорхойлон холбогдох байгууллагад материалыг хүргүүлж, дараах шагналаар шагнагдлаа.

| № | Овог, Нэр | Албан тушаал | Ажилласан жил | | Нэр дэвшүүлсэн шагналын төрөл |
|---|---|---|---|---|---|
| | | | Улсад | Шүүхийн байгууллагат | |
| 1 | Эрдэнэ-Очирын Болормаа | Ерөнхий шүүгч | 26 жил | 26 жил | Төрийн дээд шагнал “Алтан гадас одон" |
| 2 | Оюунцэцэгийн Уламмандах | Шүүгч | 8 жил | 6 жил | Хууль зүй, дотоод хэргийн яамны "Хүндэт жуух бичиг", |
| 3 | Мөнхжаргалын Энхцэцэг | Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга | 5 жил | 5 жил | Хууль зүй, дотоод хэргийн яамны "Хүндэт жуух бичиг" |
| 4 | Сумьяагийн Баяржаргал | Эвлэрүүлэн зуучлагч | 17 жил | 16 жил | Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр |
| 5 | Авирмэдийн Одончимэг | Ахлах нягтлан бодогч | 34 жил | 18 жил | Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шагнал болох “Шүүхийн тэргүүний ажилтан” тэмдэг " |
| 6 | Мэндсайханы Мөнхсайхан | Нярав | 20 жил | 19 жил | "Санхүү банкны тэргүүний ажилтан" |
| 7 | Авирмэдийн Мэндзандан | Жолооч | 17 жил | 17 жил | Монгол Улсын төрийн дээд шагнал болох “Хөдөлмөрийн хүндэт медаль” |
| 8 | Мөнхбаярын Батбаатар | Цахилгаан | 12 жил | 8 жил | Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шагнал болох “Шүүхийн тэргүүний ажилтан” тэмдэг |
| 9 | Банзрагчийн Мөнгөнцэцэг | Үйлчлэгч | 19 жил | 9 жил | Төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн хүндэт медаль" |
| 10 | Нямцэрэнгийн Нандинжаргал | Үйлчлэгч | 10 жил | 10 жил | Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шагнал болох “Хүндэт тэмдэг” |

**Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан талаар:**

1. “Шүүхийн захиргааны удирдах ажилтны сургалт, хэлэлцүүлэг” 2025.01.30



2. Шүүхийн захиргааны үйл ажиллагааны системийн (erp) нэвтрүүлэлтийн батлагдсан төлөвлөгөөний дагуу “ERP системийн танилцуулах” сургалт /**цахимаар**/ 2025.03.21

3. ”Байгууллагын архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын арга зүй, анхаарах асуудлууд” сэдэвт сургалт 2025.04.28-2025.04.29



4. “Хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал болон статистик, түүнтэй холбоотой дүрэм журмын хэрэгжилт” сэдэвт сургалт



5. Шүүхийн захиргааны үйл ажиллагааны ERP системийн хөтлөн удирдагчийн давтан цахим сургалт /**цахимаар**/ 2025.05.07

6. Эвлэрүүлэн зуучлагч нарт зориулсан "Монгол Улсад арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд "Эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан давтан болон мэргэшүүлэх сургалт" зохион байгуулах тухай 2025.05.12-2025.05.16



7. "Жендэр ба Монгол улсад тулгамдсан асуудлууд" сэдэвт сургалт /**цахимаар**/ 2025.09.10

8. "Цахим шүүх 2.0" төслийн хүрээнд Шүүхийн захиргааны үйл ажиллагааны ERP системийн идэвхжүүлэх болон шинээр нэвтрүүлэх модулиудын сургалт /**цахимаар**/ 2025.09.02-2025.09.05

9. Шүүхийн захиргааны үйл ажиллагааны ERP системийн Хяналт, шинжилгээ үнэлгээ модулийн ашиглалтын давтан сургалт /**цахимаар**/ 2025.11.03

10. "Цахим шүүх 2.0" цахим платформын "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем"-ийн таслан сэргийлэх арга хэмжээ, зөрчлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны модулиудыг нэвтрүүлэх сургалт 2025.11.17-2025.11.20



**Шүүхийн тамгын газраас зохион байгуулсан дотоод сургалтын үйл ажиллагааны талаар:**

1. Ахлах нягтлан бодогч А.Одончимэг нь “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” сэдэвт сургалтыг зохион байгууллав.



2. Шүүгчийн туслах Э.Нарантуяа нь “ Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал болон Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал” сэдэвт сургалт зохион байгуулав.



3. Жолооч А.Мэндзандан, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга М.Энхцэцэг, Б.Мөнх-Эгшиглэн нар нь албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх “Олон төрөлт байгууллагын спорт өдөрлөг”-ийг 2025 онд 1, 3, 4 дүгээр улирald 3 удаа зохион байгуулав.





4. Дорноговь аймгийн Боловсролын газраас 9-12 дугаар ангийн сурагчид ирээдүйн мэргэжил, зорилгоо тодорхойлох, өөрийн боломж чадвар, нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан ажил мэргэжлээ зөв сонгоход чиглүүлэх зорилгоор "ДАДЛАГАЖИГЧ СУРАГЧ" үйл ажиллагааг зохион байгуулж 2025.11.10-ны өдөр Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2, 3 дугаар сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчид Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн үйл ажиллагаатай танилцаж. Эрх зүйч мэргэжлийг сонгосноор ямар, ямар ажил хийх боломжтой, шүүгч, шүүхийн захиргааны ажилчид ямар ажил хийдэг талаар нээлттэй ярилцаж, тэднийг сонсох үйл ажиллагаа зохион байгууллав.





5. Олон Улсын охидын эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх жендерийн эрх тэгш байдлыг хангах үүднээс тус шүүхийн шүүгч, ажилчдын 12 охин, 11 хөвгүүдийг хамруулж “ОХИДОО ХАМГААЛЪЯ, ХӨВГҮҮДЭЭ ХАЙРЛАЯ” уриа доор үйл ажиллагаа зохион байгууллав.





6. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга М.Энхцэцэг нь шүүхийн захиргааны ажилчдад “Хэргийн индексийн журам” сэдвээр сургалтыг зохион байгууллаа.





7. Мэдээлэл технологийн мэргэжилтэн Б.Ариунболд “Үйлдлийн систем” “Дотоод сүлжээ” “ ХАСХОМ” “Шүүх хуралдааны бичлэгийг цахим хуудсанд байршуулах журам” сэдвүүдээр сургалтын зохион байгуулан албан хаагчдад мэдээлэл өгч ажиллалаа.






8. Бичиг хүргэгч М.Юмчиндулам нь “Хөдөлмөрийн тухай хууль” сэдвээр сургалт зохион байгууллаа.





9. Шүүгчийн туслах М.Хонгорзул, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга М.Энхцэцэг нар нь Ерөнхий боловсролын сургуулийн 11 дүгээр ангийн сурагчдын дунд хууль сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурагчдад эрх зүйн боловсрол олгох “БИ ХУУЛЬЧ” өдөрлөгийг зохион байгуулж, зохиомжит шүүх хуралдаан хийлээ.




10. Ахлах нягтлан бодогч А.Одончимэг нь “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах” тухай сэдвээр сургалтыг зохион байгууллаа.




11. Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын референт О.Тодбулаг тус шүүхэд 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр "Хүний эрхийн мэдрэмжтэй төрийн албаны үйл ажиллагаа, Хүний эрхийн суурь ойлголт, Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь" сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгуулж шүүгч ажилчдын сонирхсон асуултад хариулт өгч нээлттэй ярилцлаа.




12. Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Зөвлөн туслах үйлчилгээгээр дамжуулан Монгол хэл уран зохиолын ахмад багш “Үндэсний бичиг”-ийн сургалтыг зохион байгууллаа.



13. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга М.Энхцэцэг нь “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээллэх журам”, “Шүүх, шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд цахим шуудан хэрэглээх журам” сэдэвт сургалтыг зохион байгуулав.



14. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Мөнх-Эгшиглэн долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гаригт “Идвэхитэй хөдөлгөөн-Эрүүл мэнд” уриан дор Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлэв.



15. Ахлах нягтлан бодоч А.Одончимэг, эвлэрүүлэн зуучлагчийн туслах Ц.Энхзаяа нар нь “Цэвэр агаар эм” аян зохион байгуулж явган аялал зохион байгуулав.



16. Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн Э.Хэрлэнцэцэг “Хавтаст хэрэг илгээх журам” сэдэвт сургалтыг зохион байгуулав.






17. Бичиг хүргэгч М.Юмчиндулам “Ахмад настны хөдөлмөр эрхлэлт” сэдэвт сургалтыг зохион байгуулав .






18. Эвлэрүүлэн зуучлагч С.Баяржаргал “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам” сэдэвт сургалтыг зохион байгуулав .





18. Ёс зүйн дэд хорооны гишүүд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сургалт, хамт олны уур амьгалыг нэмэгдүүлэх, элдэг хөгжилтэй байх уриан дор “Хөгжөөнт тоглоом, Монита” өдөрлөгийг зохион байгуулав.










Тус шүүхийн тамгын газрын 8 албан хаагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хагас жилээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг үнэлж, зохих журмын дагуу урамшууллыг олгосон. Шүүхийн үйлчилгээний 11 албан хаагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хагас жилээр үнэлж, урамшууллыг олгосон. Тамгын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/06 дугаар тушаалаар ажилтны ээлжийн амралтын хуваарийг тэдний саналыг үндэслэн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр баталж биечлэн эдлүүлсэн. 2025 оны 05 сарын 15-ны өдрөөс тус шүүх нь 1 шүүгчтэй шүүн таслах ажиллагааг явуулж байгаа бөгөөд шүүгч Э.Болормаа нь ээлжийн амралтын **35** хоногийг /ажлын/ **биеэр эдлээгүй** болно.





**Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл:**

“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох материалыг болзол хангасан хугацаанд нь хүргүүлэн хүний нөөцийн системд баяжилтыг тухай бүрд нь оруулсан.

**Ур чадварын нэмэгдэл:**

Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журамд заасны дагуу ажилтны ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор сар бүр төрийн үйлчилгээний ажилтнуудын ур чадварыг үнэлж, албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, нэмэгдэл олгож байна





## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тус шүүх нь Төрийн албаны тухай хуульд заасан болзол шаардлыг хангасан ажилтан, албан хаагчдаар хүний нөөцөө бүрдүүлэн ажиллахад анхаарч тухай бүр Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх төрийн албаны салбар зөвлөлд сул орон тоон захиалгыг өгч тусгай шалгалтуудыг зарлуулан сул орон тоог нөхөж ажиллалаа. Одоогоор тус шүүхэд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид бүгд Төрийн албаны тухай хуульд заасан болзол шаардлагыг хангасан байна. Шүүхийн хүний нөөцийн бодлогыг хуульд нийцүүлэн зөв оновчтой зохион байгуулсж, төрийн албан хаагчийн эдлэх эрхийг хангаж төрийн албанд ажилласан жилийн болон зэрэг дэвийн нэмэгдэл, ур чадварын, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тогтоосон хугацаандаа авсан.

Шүүхийн тамгын газрын ёс зүйн дэд хороог Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүнтэй холбогдон гарсан журмуудад нийцүүлэн байгуулж, ёс зүйн дэд хорооноос алба хаагчдад зориулан хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагаа болон хамт олны дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллалаа.

2025 онд шүүхийн ажилтны хувийн хөгжлийг дэмжих сургалтуудад хамруулах, сурч хөгжих, хувь хүний ур чадвараа дээшлүүлэх үйл ажиллагаанд манлайлан, идэвх санаачилгатай оролцох, албан хаагчдад зориулсан гадаад, дотоод сургалтыг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт, хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэх, мөн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах, дасгал хөдөлгөөн тогтмол хийж хэвших, хамт олноороо зөв амьдралын дадал хэвшилтэй болох уриалга дэвшүүлж, ажил, амьдралын зохист харьцаа, тэнцвэрт байдлыг хангаж ажиллах зорилтыг шүүхийн захиргааны ажилтнууд дэвшүүлэв.

## 3.ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

### 3.1. Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны эрх, ашиг, сонирхлыг хамгаалах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Хууль зүй дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан 2021 оны А/116/65 дугаар тушаалаар баталсан “Шүүх хуралдааны дэг сахиулах,шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”-д заасны дагуу 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тамгын газар Дорноговь аймгийн Цагдаагийн газрын Замын-Үүд сумын сум дундын Цагдаагийн хэлтэстэй “2025 онд Хамтран ажиллах төлөвлөгөө”-г шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.



БАТЛАВ

БАТЛАВ

2025.01.15

Замын-Үүд сум

| № | | | |
|---|---|---|---|
| 1.1 | [illegible] | Жилдаа | [illegible] |



Шүүн таслах ажиллагааны явцад хэргийн оролцогчдоос хууль бус шаардлага тавих, шүүгч, шүүхийн ажилтнуудтай зүй бусаар харьцах, шүүх хуралдааны үед шүүгдэгч, хэргийн оролцогчоос халдлага, үймээн, хэрүүл маргаан үүссэн үед дэг сахиулж буй цагдаагийн алба хаагч нар хэрхэн шуурхай арга хэмжээ авч таслан зогсоох талаар, нэмэгдэл хүч хэрэгтэй болсон тохиолдолд хэдий хугацаанд бие бүрэлдэхүүн хүрэлцэн ирэх боломжтой эсэхийг тодруулан харилцан санал солилцлоо.

Ажлын цаг дууссанаас хойш шүүх хуралдаан зайлшгүй үргэлжлэх тохиолдолд болон олны анхаарал татсан, олон үйлдэл, оролцогчтой шүүх хуралдааныг шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг цагдаа шүүхийн албаны болон үйлчилгээний авто машинаар гэрт нь хүргэх ажлыг цагдаагийн байгууллага зохион байгуулж, дээрх дурдагдсан асуудлуудаар тус сумын сум дундын Цагдаагийн хэлтэстэй байгуулсан хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу ажиллалаа.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын Замын-Үүд сум дахь хэлтсээр галын аюулгүй байдал, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилт, галын аюулаас хамгаалагдсан байдлыг шалгуулж, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийг дүгнэлтийг гаргуулсан.


ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

0013219


ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ТАРХАЛТЫН, ДАДЛАГА, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**/Гал түймрийн улсын хяналтын байцаагчийг дүгнэлт нь 2025 оны 11 сарын 27-ны өдөр дуусаж байгаа бөгөөд уг дүгнэлтийг сунгуулах хүсэлтийг хүргүүлсэн болно./**

## 3.2. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах сэдэвт сургалтад оролцогчдод Замын-Үүд сумын Онцгой байдлын хэлтсээс “Байгууллагын галын аюулгүй байдал, “гамшгаас хамгаалах бэлэн байдал, газар хөдлөлтийн аюулын үеийн хариу арга хэмжээ сэдвүүдээр үзүүлэх дадлагыг хийж, харилцан туршлага солилцлоо.





**/гал унтраах дадлага сургуулилт хийж буй байдал/**

Шүүгчийн нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсан шинжтэй ташаа мэдээ, мэдээллийн талаар олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, нийтлэлд шүүх, шүүгчийн нэрээр сар бүр хайлт, шүүлт хийж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн зүгээс шүүгчид үзүүлэх зүй бус дарамтыг илрүүлэх ажлыг сар бүр хийсэн бөгөөд тайлант хугацаанд шүүгчийн нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсан шинжтэй гүтгэлэг, ташаа мэдээ, мэдээлэл гараагүй болно.

**Шүүгчийг хуулиар зөвшөөрсөн бие хамгаалах тусгай хэрэгслээр хангаж, хэвийн ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, энэ чиглэлээр сургалт зохион байгуулах, зааварчилгаа өгсөн талаар:**

Тус шүүх дэх 1 шүүгчид бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбоотой хүндрэл бэрхшээл гарсан эсэх, хэрэглэх шаардлага үүссэн эсэх талаар санал, асуулга авч ажилласан. Тус шүүхийн шүүгч нь 1 ширхэг цахилгаан бороохойтой ба ашиглалтын хугацаа нь дуусаагүй, эвдрэлгүй байна. Шүүгчийн ажлын өрөөнд болон шүүх хуралдааны танхимд эрсдэл тохиолдсон үед яаралтай дуудлага өгөх зорилгоор шүүгчийн суух ширээний тавцангийн баруун доод хэсэгт дуудлагын хонх байрлуулсан ба уг хонх нь хамгаалалтын цагдаа байрших хэсэгт хаалганы дугаараар харагдах байдлаар мэдээлэл очно. Энэ нь шүүгчийн аюулгүй байдлыг хангахад чухал нөлөө үзүүлэх хэрэгслийн нэг төрөл болон ашиглагдаж байна.



**/Шүүгчийн ширээнд байрлуулсан шуурхай тохиолдолд цагдааг дуудах хонх/**

Мөн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тамгын газар, Замын-Үүд сумын сум дундын цагдаагийн газар хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу сум дундын шүүхийн байрны хамгаалалтын бүсийг тогтоосон.



**Шүүх хуралдааны аюулгүй байдлыг зохих журам, стандартын дагуу хангасан талаар:**

Дорноговь аймгийн Цагдаагийн газрын Замын-Үүд сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах хэсэг тус шүүхийн байранд 3 алба хаагч 24 цагаар, дэг сахиулагчаар 1 албан хаагч 8 цагаар тасралтгүй үүрэг гүйцэтгэн шүүхийн барилга байгууламжийн гадна, дотор талын хөдөлгөөнийг тогтмол хянаж, шүүхийн байранд нэвтэрсэн, иргэний бичиг баримтыг шалган бүртгэлд авч, зохих журмын дагуу шүүх байранд 1638 иргэн нэвтрүүлснээс шүүх хуралдаанд 769, шүүгчтэй 1, тамгын газрын даргатай 4, шүүгчийн туслах болон бусад ажилтантай 864 иргэн уулзахаар тус тус нэвтэрсэн байна.




Шүүхээр үйлчлүүлэхээр ирсэн иргэдийг нэвтрүүлэхдээ бичиг баримтыг шалган бүртгэл хөтлөхөөс гадна шүүх хуралдаанд оролцогчид болон шүүх рүү нэвтэрч буй иргэдэд түр нэвтрэх үнэмлэх олгон шүүхийн ажилтан, шүүгч нарт үйлчлүүлэгчдийн мэдээллийг түр үнэмлэхээр дамжуулан өгч байна. Уг энгэрийн тэмдэг нь иргэд болон шүүх хуралдаанд оролцох оролцогчдыг шүүхийн байранд чиглүүлэх зорилготой юм.





/Шүүх хуралдаанд оролцогчдод болон шүүгч, тамгын газрын ажилтнуудтай уулзах иргэдийн түр үнэмлэх/

Шүүхийн ажилтнуудтай уулзах, түр нэвтрэх иргэдийг нэвтрэхээс өмнө тухайн этгээдийн биед зэвсэг, зэвсгийн чанартай бусдад аюул учруулж болохуйц зүйл байгаа эсэхийг металл илрүүлэгч багажаар шалган дотогш нэвтрүүлж байна. Шүүхийн ажилтнуудтай уулзах, түр нэвтрэх иргэдийг нэвтрэхээс өмнө тухайн этгээдийн биед зэвсэг, зэвсгийн чанартай бусдад аюул учруулж болохуйц зүйл байгаа эсэхийг металл илрүүлэгч багажаар шалган дотогш нэвтрүүлж байна. Энэ нь шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, аюул учруулахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.



**/Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн хуралдаанд оролцогчдын эд зүйлийг хадгалах хайрцгийн зураг/**

2025 онд тус шүүхийн шүүх хуралдааны 1, 2 дугаар танхимд нийт 1892 шүүх хуралдаан явагдсан бөгөөд үүнээс эрүүгийн хэргийн 167, иргэний хэргийн 164, зөрчлийн хэргийн 1579, таслан сэргийлэх арга хэмжээний 18 шүүх хуралдаан болов. Үүнээс Эрүүгийн 167, зөрчлийн 617, нийт 784 шүүх хуралдаанд хамгаалалтын цагдаа нь дэг сахиулж хяналт тавьж хамгаалалтын үүрэг гүйцэтгэж ажилласан ба шүүх хуралдаанд оролцогч, шүүгдэгч, бусад оролцогч нар шүүх хуралдааны дэг журам зөрчсөн үйлдэл гаргаагүй, шүүх хуралдаан хэвийн явагдсан болно.



**/Шүүх хуралдаан явагдаж буй байдал/**

Эрүүгийн хэрэгт хорих ялаар шийтгэгдсэн ялтныг Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд 10, Зөрчлийн тухай хуулиар 7-30 хоногийн баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн 89 холбогдогчийг Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын баривчлах байранд албаны машин болон суудлын галт тэргээр хуяглан хүргэж нийт давхардсан тоогоор 95 удаагийн явалтаар 7 албан хаагч зөрчил дутагдалгүй хуяглан хүргэж үүрэг гүйцэтгэсэн байна.


ЗАМЫН-ҮҮД СУМЫН СУМ ДУНДЫН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЭСЭГ

Хуяглан хүргэлтийн бүртгэл

2025 ОН


ХУЯГЛАН ХҮРГЭЛТИЙН БҮРТГЭЛ

| № | Овог нэр РД | Шүүхийн шийтгэх дугаар | Огноо | Авсан арга хэмжээ | Хүлээн авсан албан хаагч |
|---|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 2 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 3 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 4 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 5 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 6 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 7 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 8 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 9 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 10 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 11 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 12 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 13 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 14 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

Тус шүүхийн Тамгын газар нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, холбогдогчийн түр саатуулах өрөөний аюулгүй байдлыг хангаж, хяналт тавин ажиллаж байна.



**/Түр саатуулах өрөө/**

**Шүүхээр үйлчлүүлэх иргэдийг ая тухтай нөхцөл байдлаар хангах**

Шүүхийн байрны 1 давхарт шүүхээр үйлчлүүлэгч иргэдийн хувцас өлгөх өлгүүр, гар тээшийг түр хадгалах сейф байрлуулсан. Шүүх хуралдаанд оролцогч нар эд зүйлсээ аюулгүй, найдвартай түр хадгалах боломжоор хангаж өгсөн.



**/Үүдний хүлээлгийн хэсэгт иргэдийн хувцас, эд зүйл хадгалах сейфийг байршуулсан байдал/**

Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан булан, дуудлагын хонх, зориулалтын налуу замыг бэлтгэн шүүхээр үйлчлүүлэх боломжийг ханган ажиллаж байна.






**/Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан дэмжих булан болон налуу замын хэсэг/**

## Шүүгч, шүүхийн ажилтнуудын албан өрөөнд буй эд зүйл, баримт бичгийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй ажил

Шүүгч, шүүхийн ажилтны аюулгүй байдлыг хамгаалах болон хавтаст хэрэг, эд мөрийн баримт, шүүн таслах ажилтай холбоотой мэдээлэл алдагдахаас сэргийлэх, тэдгээрийн хадгалалт хамгаалалтыг хангах зорилгоор тус шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд өөрсдийн өрөө тасалгааг ажил тарахад лацдан цагдаагийн ажилтанд хүлээлгэн өгч ажиллаж байна.







/Өрөө тасалгааг лацдан цагдаагийн алба хаагчид хүлээлгэн өгдөг байдал/

Тус шүүхийн бүх албан тасалгаа, өрөөнүүдийн хаалганы лац тэмдгийг шинэчилж, уг лац тэмдгийг шүүхийн ээлжийн хамгаалалтын цагдаатай өдөр бүр бүртгэлээр хүлээлцэж, тус бүртгэлд хяналт тавин ажиллаж байна.






/Лац хүлээлгэн өгч буй байдал/

## Шүүхийн аюулгүй байдлыг хангах, шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хамгаалах бусад арга хэмжээг зохих журмын дагуу хэрэгжүүлэх

Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлж Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн шүүхийн байранд цагдаагийн хэв журмын 3 алба хаагч 24 цагаар гадна, дотно талд хяналт тавин ажиллаж байна.




**/Цагдаагийн албан хаагч гадна, дотно камерыг хянаж буй байдал/**

2025 онд шүүгчийн хараат бус, аюулгүй байдалд халдсан шинжтэй үйлдэл, мөн шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан тохиолдол гараагүй байна.

Тус шүүхийн шүүгч шүүх бүрэлдэхүүнд оролцохоор өөр шүүхэд томилолтоор ажиллахад сумын Цагдаагийн хэлтсийн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгээс харуул хамгаалалтын ажлыг зохион байгуулж, шүүх хуралдаан оройтож дууссан, илүү цагаар ажиллаж оройтож тарсан тохиолдолд шүүгч нарыг гэрт нь аюулгүй хүргэх ажлыг цагдаагийн байгууллагын алба хаагч нараар гүйцэтгүүлэн ажиллаж байна.



Тус шүүх нь 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар эрүүгийн 133 хэрэг, иргэний 148 хэрэг, зөрчлийн хэрэг 1539, таслан сэргийлэх арга хэмжэний саналтай 18, нийт 1838 хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд тайлангийн хугацаанд шүүгчид нөлөөлсөн нөлөөлөл болон шүүгчийн хувийн эрх, нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсан шинжтэй гүтгэлэг, доромжлол, мэдээ, мэдээлэл гараагүй байна. Мөн шүүх дэх шүүхийн харуулын эд зүйлийг тогтмол хүлээлцэж тэмдэглэл үйлдэж байна.







**/Эд зүйл хүлээлцсэн байдал/**

Яллагдагч, шүүгдэгч, ялтныг тусгаарлах өрөөг давхар хянах үүднээс тусгаарлах өрөө бүрэн харагдахуйц хяналтын камерыг байршуулсан.





**/Тусгаарлах өрөөг камераар хянаж буй байдал/**

**Шүүгчээс хөтөлсөн нөлөөллийн мэдүүлэг, тэмдэглэлийг холбогдох журамд заасны дагуу нууцлалыг хангаж ажилласан талаар:**

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2020 оны 17 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам”-ын дагуу нөлөөллийн мэдүүлгийн баримтыг хэргийн оролцогч нарт танилцуулж, хууль тогтоомжийг тайлбарлан ажиллаж, аливаа этгээдээс шүүгчийн хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогыг хязгаарлаж ажилласнаар 2025 онд тус шүүхийн шүүгч, шүүх бүрэлдэхүүнд шүүн таслах үйл ажиллагаанд хэргийн оролцогч болон бусад этгээд, хуулийн этгээдийн зүгээс нөлөөлөх оролдлого гаргасан тохиолдол байхгүй байна.

Шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх аливаа оролдлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор хэргийн оролцогч, зохигчдод тухай бүр нөлөөллийн мэдүүлгийг тайлбарлан танилцуулж, нөлөөлсөн эсэх талаар шүүгчээр баталгаажуулж ажиллалаа. Мөн нөлөөлөл мэдүүлэг, нөлөөлөл тэмдэглэл тэмдгийг холбогдох журамд заасны дагуу хийлгүүлж, нууцын ажилтан хариуцан шүүхэд нөлөөлөх орлого гаргасан тохиолдолд зохих журмынд дагуу хэрэглэх бэлтгэлийг хангаж ажиллаж байна.






**Шүүх, шүүхийн байрны гадна орчинд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэх, шүүгч, гэрч, хохирогчийн амь биед халдах, барьцаалах, байгалийн аюулт үзэгдэл, осол, гамшиг гарах үед холбогдох арга хэмжээг цагдаагийн байгууллага болон шаардлагатай тохиолдолд бусад хууль сахиулах байгууллагатай хамтран хэрэгжүүлэх**

Шүүх хуралдааны танхимд шүүн таслах ажлыг олон нийтэд нээлттэй ил тод явуулах, эрүүл аюулгүй хэвийн нөхцөл байдлыг бүрдүүлсэн эсэхийг нээлттэй байлгах үүднээс шүүхийн байрны хүлээлгийн танхимд шүүх хурлыг шууд дамжуулах дэлгэц байрлуулсан. Мөн хэрэгт хохирогч, гэрчээр оролцож байгаа насанд хүрээгүй хүүхдийг хууль ёсны төлөөлөгчийн хамт хэргийн шүүгдэгчээс тусгаарлах зорилгоор тусгайлан бэлтгэсэн хүүхдийн өрөөнд дэлгэцээр шууд холбогдох байдлаар шүүх хуралдаанд оролцуулж байна. Энэ нь хүүхдийн айж түгших, сэтгэл санааны хямралд орохоос урьдчилан сэргийлэх мөн аюулгүй байдлыг бүрэн хангахад чиглэсэн болно.



**/Хүүхдийн өрөө/**

Эд мөрийн баримт хадгалах өрөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох журмыг баримтлан тусгай бэлтгэсэн өрөөнд хадгалан бүртгэл үйлдэж бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх үүднээс тусгай өрөөг байнга лацдан харуулын цагдаагийн албан хаагчид бүртгэлээр хүлээлгэн өгч ажиллаж байна.







Прокурорын байгууллагаас эрүүгийн хэрэгт эд мөрийн баримтаар ирүүлсэн эд мөрийн баримтуудыг эд мөрийн баримтын өрөөнд хадгалан хаалгыг тусгай лацаар лацдаж шүүхийн харуулын цагдаагийн албан хаагчид бүртгэлээр хүлээлгэн өгдөг.

Тус шүүхийн архивд эрүү, иргэн, зөрчлийн хэрэг, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны материал, шүүхийн тамгын газар болон санхүүтэй холбоотой бичиг, бусад баримт бичигт хадгаламжийн нэгж үүсгэн архивд хүлээн авч хадгалдан, хадгалалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хууль зүй дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан 2021 оны А/116/65 дугаар тушаалаар баталсан “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тамгын газар Дорноговь аймгийн Цагдаагийн газрын Замын-Үүд сумын сум дундын цагдаагийн хэлтэстэй “2025 онд Хамтран ажиллах төлөвлөгөө”-г шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд шүүхийн байрны хамгаалалтын бүс, шүүгч нарын гэр хүрэх маршрут зэргийг тогтоосон схем зураг гарган батлуулж уг схемийн дагуу шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалан ажиллаж байна.

2026 онд шүүгчдэд бие хамгаалах арга техникийн анхан шатны мэдлэг олгох, дадлага сургуулилт цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллах, мөн шүүгч нарт жижиг авсаархан цахилгаан бороохой, нулимс асгаруулагч авах асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Мөн эрэн сурвалжлах, албадан ирүүлэх шүүгчийн захирамжийг хугацаанд нь гүйцэтгэх, биелэлтийг хангаж ажиллах талаар цагдаагийн байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулж, шүүхийн шийдвэр, захирамж, шийдвэрийн биелэлтийг хангах ажилд тамгын газраас тавих хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

## 4. ШҮҮХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

### 4.1. Батлагдсан төсөв,цалингийн сан, орон тоонд багтаан төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулах, бүртгэх, тайлагнах ажлыг зохион байгуулах чиглэлээр

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх нь 2025 онд 1,689,333,000 төгрөгийн төсөв батлуулж, эхний 11 сарын байдлаар 1,474,815,500 төгрөгийн урсгал санхүүжилт авч 1,389,263,800 төгрөгийг шүүн таслах ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад зарцуулан ажиллаж байна.

2025 онд 23 хүний орон тоотойгоор цалингийн сан батлагдсан ба 2025 оны 03 дугаар сараас архивчийн 1 орон тоо нэмэгдэж, 24 орон тоотой ажиллахаар байсан боловч тайлант хугацаанд 1 шүүгч өндөр насны тэтгэвэрт гарч 3 шүүгч, 1 тамгын газрын даргын орон тоо дутуу ажиллаж, цалингийн сан хэмнэлттэй байна. Мөн цалингийн сангийн хэмнэлттэй холбоотой нийгмийн даатгалын шимтгэл сан хэмнэлттэй ажилласан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 15 дугаар зүйл, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2022 оны 05 дугаар сарын 19-ний №109 тоот зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Батлагдсан төсвийн зардлуудыг төрийн сангийн удирдлагын систем https://finance.gov.mn / -р төлбөрийн гүйлгээг хийж гүйцэтгэж байна.

НЭВТРЭЛТИЙН НЭГДСЭН СИСТЕМ

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ

*/Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар эдийн засгийн ангилал бүлгийн дүнгээр нь харуулбал /*

| Д/д | Үзүүлэлт | Батлагдсан төсөв | | Олгосон санхүүжилт /өссөн дүнгээр/ | Гүйцэтгэл /өссөн дүнгээр/ | Зөрүү /тайлант үе/ |
|---|---|---|---|---|---|---|
| | | Жилээр | Тайлант үе | | | |
| 1 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 1,888.718.600 | 1.480.505.700 | 1.480.505.700 | 1.389.233.969 | 91.271.731 |
| 2 | Нийт зарлага | 1,888.718.600 | 1.480.505.700 | 1.480.505.700 | 1.389.233.969 | 91.271.731 |
| 3 | Бараа ажил үйлчилгээний зардал | 1,686.218.600 | 1.263.992.100 | 1.263.992.000 | 1.172.720.369 | 91.271.631 |
| 4 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1.266.283.200 | 983.835.000 | 983.835.000 | 903.669.519 | 80.165.481 |
| 5 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 158.285.400 | 123.072.200 | 123.072.200 | 112.441.742 | 10.630.458 |
| 6 | Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал | 55.000.000 | 50.456.900 | 50.456.900 | 50.456.900 | |
| 7 | Хангамж, бараа материалын зардал | 67.500.000 | 51.672.200 | 51.672.200 | 51.672.200 | |
| 8 | Нормативт зардал | 800.000 | 133.500 | 133.500 | 133.500 | |
| 9 | Эд хогшил, урсгал засварын зардал | 50.000.000 | 35.509.400 | 35.509.400 | 35.509,400 | |
| 10 | Томилолт, зочны зардал | 20.000.000 | 12.651.200 | 12.651.200 | 12.651.100 | 100 |
| 11 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 18.350.000 | 6.661.700 | 6.661.700 | 6.186.008 | 475.692 |
| 12 | Нийгмийн хамгаалал | 202.500.000 | 216.513.600 | 216.513.600 | 216.513.600 | |
| 13 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал , дэмжлэг | 202.500.000 | 216.513.600 | 216.513.600 | 216.513.600 | |
| 14 | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 1.888.718.600 | 1.480.505.700 | 1.480.505.700 | 1.480.505.700 | |
| 15 | Улсын төсвөөс санхүүжих | 1.888.718.600 | 1.480.505.700 | 1.480.505.700 | 1.480.505.700 | |

Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал нь 2025 онд 4 орон тоо дутуу ажиллаж цалингийн хэмнэлт гарсан. Нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал цалингийн сангийн хэмнэлттэй холбоотой хэмнэгдсэн. Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал цэвэр, бохир усны зардал болон гэрэл, цахилгааны төлбөр хэмнэлттэй ажиллаж байна.

Хангамж бараа материалын зардлыг шүүн таслах үйл ажиллагааг хэвийн явуулахад зориулагдсан бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, БҮТЭЗ зэрэг зардалд зарцуулагдаж байгаа бөгөөд тээвэр шатахууны зардлаас бусад зардал хэмнэлттэй ажиллаж ирлээ.

Нормативт зардал одоогийн байдлаар зарцуулагдаагүй байна.

Эд хогшил, урсгал засварын зардлыг дараах байдлаар зарцуулсан.

Үүнд: Багаж хэрэгслийн зардлаас 3,000,000 төгрөгөөр 2 ширхэг архивын нягтруулах шүүгээ, 849,800 төгрөгөөр 2 ширхэг сэтгүүлийн ширээ, 607,800 төгрөгөөр мөн 2 ширхэг сандлыг тус тус авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн.





Урсгал засварын зардлаас 09-11 ДГН Рено дастер маркийн автомашинд 2,286,450 төгрөгийн сэлбэг хэрэгсэл авч тавьсан. Өвөл болон зуны тос тосолгооны материал авч бүрэн сольсон.



Урсгал засварын зардлаар “Бүтээлч Энх Ган Ану" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 6,915,800 төгрөгөөр паркетан шал худалдан авч Шүүхийн байрны 1 давхарын Үйлчилгээний танхимын 153,7м2 шал, хүүхдийн өрөө, эвлэрүүлэн зуучлагчийн өрөө, эвлэрүүлэн зуучлагчийн туслахын өрөө зэрэг өрөөнүүдийн шалыг шинээр солисон.





/**Шүүх**ийн үйлчилгээний танхим болон 1 давхарын коридорын шалыг бүрэн солив /

Мөн аюлгүйн гарцны хаалга, 2 давхарын өрөөнүүдийн цонх хуучирч муудсан тул шинээр вакум цонх, хаалга хийж засварлан. Хүүхдийн өрөө, эвлэрүүлэн зуучлалын өрөө, эвлэрүүлэн зуучлагчийн туслахын өрөөнд засвар хийв.





/2 давхарын 7 өрөөний цонхыг шинээр солив/




**/Эз болон эз-н туслахын өрөөг бүрэн засварлав/**

Мэдээлэл технологийн зардлыг Zoom лицензийн эрхийг 750,000 төгрөгөөр, Болор дуран 390,000 төгрөгөөр тус тус эрхийг сунгуулсан.

## 4.2.Шүүхийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, норм стандартын дагуу үндэслэлтэй боловсруулах

Тус шүүх нь 2025 онд батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Зайлшгүй шаардлагатай нэмэлт санхүүжилт шаардагдах болсон тохиолдолд ШЕЗ-д уламжлан санхүүжилтийг нэмж тавиулсан. 2026 оны төсвийн төслийг боловсруулан хуулийн хугацаандаа Шүүхийн Ерөнхий Зөвлөлд хүргүүлсэн.



/2026 оны төсвийн төсөл хүргүүлсэн байдал/



Худалдан авах ажиллагаа төлөвлө…
тайлагнах журмын хавсрал…
МАЯГТ-…

Батлав … Тамгын газрын дарга Э.Нарантуяа

2025 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ төлөвлөгөө

| № | Тендер шалгаруулалтын код | Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал | Төрөл (бараа, ажил үйлчилгээ) | Нийт төсөвт өртөг / мян.төг/ | Тухайн онд санхүүжих дүн / мян.төг / | тендер шалгаруулалтын арга | Тендер шалгаруулалт зарлах сар | Тогтоогдсон худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлт тавих эсэх | Тайлбар годруулга |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| | | Төсвийн хөрөнгө оруулалт | | | | | | | |
| | | дүн | | | | | | | |
| | | Урсгал төсөв | | | | | | | |
| 1 | | Бичиг хэрэг | бараа | 20000.0 | 20000.0 | шууд худалдан авалт | | | |
| 2 | | Тээвэр шатахуун | бараа | 20000.0 | 20000.0 | шууд худалдан авалт | | | |
| 3 | | Урсгал засвар | ажил үйлчилгээ | 50000.0 | 50000.0 | шууд худалдан авалт | | | |
| | | дүн | | 90000.0 | 90000.0 | | | | |
| | | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт | | | | | | | |
| | | дүн | | | | | | | |
| | | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө | | | | | | | |
| | | дүн | | | | | | | |

Хянасан:
Боловсруулсан

Тамгын газрын дарга Э.Нарантуяа
Ахлах нягтлан бодогч А.Одончимэг

/2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан гаргаж хүргүүлсэн байдал./

## 4.3.Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг иж бүрэн, үнэн зөв, хуульд заасан хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээг сар бүр үнэн зөв гаргаж, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн санхүү хөрөнгө оруулалтын газарт сар бүрийн 01-нд цахимаар, харьяа төрийн санд сар бүрийн 05-ны дотор цаасаар хүргүүлж хэвшсэн. 2025 онд Төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу төсвийг үр ашигтай зарцуулж, өр авлагагүй ажиллаж байна. Мөн шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг материалаар бүрэн хангаж ажиллалаа. 2025 онд хөрөнгө оруулалтын санхүүжилт байхгүй.

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2025 оны 01 сарын 15-ны өдрийн хооронд Дорноговь аймгийн Төрийн Аудитын газраар баталгаажуулсан. 2024 оны санхүүгийн тайланд түүврийн аудит орсон ба 2025 оны 02 дугаар сард хуулийн хугацаандаа Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Санхүү хөрөнгө оруулалтын газарт тушаасан.







/2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2025 оны 1, 2, 3-р улирлын санхүүгийн тайлан тушаасан байдал/

2025 оны 1, 2, 3 дугаар улирлын тайлан балансыг мөн хуулийн хугацаандаа Е-тайланд шивж баталгаажуулан Санхүү хөрөнгө оруулалтын газарт тушаасан болно.

## 4.4.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан анхан шатны баримтын бүрдлийг хангах

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, УСНББОУСТ, төсвийн ерөнхийлөн захирагчийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөн, Төсвийн ерөнхийлөн захирагч болон холбогдох эрх бүхий байгууллагаас ирсэн чиг үүрэг, зөвлөмжийн дагуу ажиллаж байна. Санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан Сангийн яамны **Acolous**, **Finanic.gov.mn** программууд дээр бүртгэж, бүх тайлан мэдээг программаас гарган, санхүүгийн үйл ажиллагааг зөрчилгүй явуулж байна. Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт”-ын дагуу мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн анхан шатны баримтуудыг хөтөлж, тайлан бүртгэлд тусгаж байна.

## 4.5.Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт,хадгалалт, хамгаалалт,бүрэн бүтэн байдлыг хангах

Тус шүүх нь 2025 оны эхэнд 824,284,564.20 төгрөгийн үндсэн хөрөнгө, 40,801,259,48 төгрөгийн бараа материалтай байсан ба оны туршид 253,240,595,65 төгрөгийн үндсэн хөрөнгө, 57,648,584 төгрөгийн бараа материал нэмэгдэж, 57,366,614 төгрөгийн бараа материалыг шүүн таслах үйл ажиллагааг хэвийн явуулахад зарцуулж, 30,836,242,25 төгрөгийн хөрөнгийн элэгдэл гаргасан байна. 2025 оны 11 сарын 19-ний өдрийн байдлаар 1,120,524,759.85 төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 41,083,229.48 төгрөгийн бараа материалтай байна.

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан НХ Маягт БМ-10 маягтын дагуу шүүгч, ажилтнуудад хэрэглэгдэж байгаа хөрөнгийг эзэмшигч тус бүрээр эзэмшигчийн карт хөтлөн гарын үсэг зуруулан баталгаажуулж байна. Мөн эд хариуцагч бүртэй эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулан баталгаажуулдаг ба жил бүр гэрээг шинэчлэн байгуулж байна. Тамгын газрын даргын тушаалаар батлагдсан тооллогын комисс жилд хагас болон бүтэн жилээр тооллого хийж эд хөрөнгө тус бүрийг эд хөрөнгийн бүртгэлийн карттай тулган тооллогыг хийж, НХ маягт БМ-7 маягтын дагуу тооцоо бодсон акт үйлдэн, тооллогын илтгэх хуудас, хурлын тэмдэглэлийн хамт тайлан балансt хавсарган Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлдэг. Тамгын газрын даргын тушаалаар томилогдсон Өмч хамгаалах зөвлөл нь 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр 2025 онд хийх ажлын төлөвлөгөөгөө гарган батлуулсан. Өмч хамгаалах зөвлөл нь Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын дагуу жил бүр төлөвлөгөө гарган батлуулж, уг төлөвлөгөөний дагуу хийх ажлуудаа 2025 онд бүрэн хэрэгжүүлсэн. Мөн үндсэн хөрөнгө, хангамжийн материалд хяналт тавьж ажиллаж ирсэн ба 2025 оны 11 сарын байдлаар 2 удаа хуралдаж, үндсэн хөрөнгө данснаас хасах болон ашиглах боломжтой ашиглах хугацаа дуусаж, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн жагсаалтыг гарган Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр гарган Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 323 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн болон захиргааны статистикийн маягтыг “Төрийн өмчийн бүртгэлийн цахим”-д 2025 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй байгаа хөрөнгүүдийн 2025 оны хуримтлагдсан элэгдлийг бодуулж, он шилжүүлж, орлого, зарлага болон 2025 оны санхүүгийн тайланг үнэн зөв, бүрэн оруулсан.

## 4.6. Ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах, шилжүүлэх эсхүл худалдах асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлүүлж биелэлтийг хангаж ажилласан талаар:

2025 оны эхний хагас жилийн тооллогоор актлах санал гарсан, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон 34 нэр төрлийн 73 ширхэг 11,951,360 төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасуулахаар 2025 оны 10 сард Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлсэн. Мөн ашиглалтын хугацаа дууссан болович дахин ашиглах боломжтой 46 нэр төрлийн 109 ширхэг 58,426,992 төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ шинэчлэн тогтоож ашиглах хугацааг сунгуулахаар Төрийн Өмчит Бодлого Зохицуулалтын газарт Шүүхийн Ерөнхий зөвлөлөөр уламжлуулан хүргүүлсэн.


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ

Тус шүүхийн 2025 оны эхний хагас жилийн тооллогоор данснаас хасах санал гарсан, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжгүй болсон 34 нэр төрлийн73 ширхэг 11,951,360 / арван нэгэн сая есөн зуун тавин нэгэн мянга гурван зуун жар / төгрөгийн хөрөнгийг данснаас хасуулах саналыг ТӨБЗГ-т уламжилж холбогдох шийдвэрийг гаргуулж өгнө үү.

Хавсралт 34 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ШҮҮГЧИЙН ТУСЛАХ М.ХОНГОРЗУЛ

1371001


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ

Тус шүүхийн 2025 оны эхний хагас жилийн тооллогоор элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн ч цаашид ашиглах боломжтой санал гаргасан үнэ болон ашиглах жилийг шинэчлэн тогтоосон 46 нэр төрлийн 109 ширхэг 58,426,992 / тавин найман сая дөрвөн зуун хорин зургаан мянга есөн зуун ерэн хоёр / төгрөгийн хөрөнгийг ажиллах хугацааг сунгах, үнэ шинэчлэн тогтоолгохоор ТӨБЗГ-т уламжилж холбогдох шийдвэрийг гаргуулж өгнө үү.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ШҮҮГЧИЙН ТУСЛАХ М.ХОНГОРЗУЛ

1371005

Тус шүүхийн шүүгчээр ажиллаж байсан шүүгч Б.Нармандах нь Орхон аймгийн шүүхэд шүүгчээр томилогдсон тул өөрийн хэрэглэж байсан зөөврийн компьютерийг Орхон аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд балансаас балансад шилжүүлэхээр Төрийн Өмчит Бодлого Зохицуулалтын газарт хүсэлт гарган уламжлуулахаар Шүүхийн Ерөнхий зөвлөлд баримт материалыг хүргүүлсэн.


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ

Тус шүүхийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй HP маркийн 2,587,120 /хоёр сая таван зуун наян долоон мянга нэг зуун хорь/ төгрөгийн үнэтэй 1 ширхэг зөөврийн компьютерыг шүүгч шилжсэн тул Орхон аймаг дахь шүүхийн тамгын газарт балансаас балансад шилжүүлэн өгнө үү.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ШҮҮГЧИЙН ТУСЛАХ М.ХОНГОРЗУЛ

1371003

2025 оны 11 дүгээр сард ТӨБЗГ-аар 2024 оны Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэн **93**%-ийн үнэлгээ авсан болно.

**4.7.Цалин, хөлс, татвар, даатгалын тайлангийн уялдааг хангах, өр авлагагүй ажиллах**

Тус шүүхийн шүүгч ажилтнуудын цалин хөлсийг Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр бодож байгаа бөгөөд сард 2 удаа олгож байна. Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн https://payroll.gov.mn / системээр цалин хөлс, тэтгэмжийг бодож олгодог. Дээрх системд байгууллагын ерөнхий мэдээлэл, дотоод нэгж, албан тушаал, орон тоо, ажилтнуудын мэдээлэл /цалин хөлс, нэмэгдэл, албан тушаалын өөрчлөлт/, хүний нөөцтэй холбоотой тушаал, шийдвэр зэргийг тухай бүр шинэчлэн оруулж, цалинг уг системээр тооцон олгож байна. Цалингийн мэдээллийг дээрх системд бүртгүүлсэн цахим шуудангийн хаягаар шүүгч, ажилтнуудад хүргүүлж хэвшсэн.

Цалин хөлстэй холбоотой тушаал шийдвэрүүдийг цаг хугацаанд оруулж ажилладаг бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ын өр авлагагүй ажилласан. Цалин хөлсний мэдээ тайланг сар бүр ШЕЗ-ийн Санхүү хөрөнгө оруулалтын газарт мэдээлдэг ба сар бүр нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг https://portal.ndaatgal.mn/ цахим сайтаар гарган илгээж, дараа сарын 05-ны дотор баталгаажуулж хэвшсэн.

https://etax.mta.mn/ цахим татварын системд улирал бүр цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгах татварын тайлан ТТ-11 тайланг гаргаж хүргүүлдэг ба татварын өр авлагагүй ажиллаж байна

**4.8.Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд www.shilendans.gov.mn сайтад үнэн зөв иж бүрэн байршуулах**

Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг дараа сарын 08-ны дотор сангийн яамны **www.shilendans.gov.mn** цахим хуудаст тогтмол мэдээлсэн.

Мөн шүүхийн ил тод байдлын мэдээллийн самбарт байршуулж байна. Шилэн дансны сайтаар илгээгддэг улирал, сар тайланг тогтмол хугацаанд нь илгээж ажиллалаа.

1. Шилэн дансны цахим хуудсанд тухай бүр оруулах мэдээллийг нийт 8 төрлөөр нь сар бүр оруулж нийт 11 удаа мэдээлэл оруулж баталгаажуулсан.

2. Сар бүр оруулах 3 төрлийн мэдээллийг 2025 онд тус бүрийг 11 удаа оруулж баталгаажуулсан.

3. Улирал бүр оруулах төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээллийг 2025 эхний 3 улирлыг бүрэн оруулсан.

4. Бүтэн жилээр оруулах байгууллагын батлагдсан төсөв 2025 оны 01 дүгээр сарын 08-нд хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөв гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл гэсэн мэдээг 01 дүгээр сарын 10-нд, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 01 дүгээр сарын 10-ны дотор тус тус цахим мэдээллийн санд оруулсан.

5. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тайланг 2024 оны жилийн эцэс болон 2025 оны 1, 2, 3-р улирлын байдлаар гаргаж хүргүүлсэн. Шилэн дансны улирлын тайланг 4 удаа гаргаж цахимаар илгээсэн.

### Аудитын дүгнэлт, зөвлөмж

2024 оны жилийн эцсийн балансыг хуулийн хугацаанд нь Дорноговь аймгийн Төрийн аудитын газар баталгаажуулсан ба түүвэр аудитад орсон. Шүүхийн Ерөнхий зөвлөлд цаг хугацаанд нь тушаасан ба шалгалтаар ямар нэг албан шаардлага, зөвлөмж аваагүй болно.

### Төсөв, санхүүгийн ил тод байдал

Шүүхийн нээлттэй ил тод байдал, Шилэн дансны хуулийн дагуу тус шүүхийн хөрөнгө санхүүгийн талаар нээлттэй ил тод байлгах зорилготой шүүхийн 1-р давхарт шүүхийн төсөв санхүүгийн ил тод мэдээллийн самбар байршуулан Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, тайлант жилийн төсөв, төсвийн төсөл тендер шалгаруулалт болон дуудлага худалдаа, тайлант жилийн төсвийн гүйцэтгэл, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний талаарх мэдээллийг сар бүр шинэчлэн гаргаж тогтмол ажиллуулж хэвшсэн.




Шүүхийн цахим хуудас болон Шилэн дансны нэгдсэн порталд шилэн дансны цэсийн дагуу бүх мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь оруулан ажиллаж байна.

### ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, УСНББОУС, Анхан болон Давж заалдах шатны шүүхийн тамгын газрын НБББББ-ийн дагуу байгууллагын санхүү, төсвийг захиран зарцуулж, төсвийн ерөнхийлөн захирагч болон холбогдох эрх бүхий байгууллагаас ирсэн үүрэг, чиглэл, зөвлөмжийн дагуу ажиллалаа. Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгаа удирдах чиглэлээр тус шүүхийн Тамгын газар нь 2025 онд батлагдсан төсвийг Төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу үр ашигтай зарцуулж, өр, авлагагүй ажиллаж байна.

Мөн шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг материалаар бүрэн хангаж ажилласан бөгөөд энэ онд тус шүүхийн тамгын газар нь шүүн таслах ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад анхаарч ажиллалаа.

## 5. МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

### 1. Шүүхийн цахим хуудас, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулах, мэдээллийн шуурхай хүртээмжтэй байдлыг хангах

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх нь ***court.zamin-uud.do.gov.mn*** сайтаар дамжуулан тайлант хугацаанд шүүх хурлын тов 33, шүүх хуралдааны тойм мэдээ 28, мэдээ, мэдээлэл 8, шүүхийн шийдвэрийн тойм 4-г тус тус байршуулж иргэдийг мэдээллээр хангаж ажилласан байна.




Мөн Замын-Үүд шүүх фэйсбүүк хуудас болон Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн Тамгын газар, Замын-Үүд сум дахь шүүхийн Эвлэрүүлэн зуучлал гэсэн цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.









Тус шүүхийн Тамгын газраас иргэдэд хүргэх шүүхийн үйлчилгээ, нээлттэй байдлын мэдээллийн цахим болон биет орчны сайжруулах, чанар үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор шүүхийн үйлчилгээний хэсэгт мэдээллийн самбар, нэхэмжлэл, хүсэлтийн загвар зэргийг байршуулсан бөгөөд дэлгэцээр шүүхийн үйлчилгээний талаарх шторкийг өдөр бүр гаргаж байна. Мөн цахимаар www.court.zamiin-uud.do.gov.mn сайт болон Замын-Үүд шүүх нэртэй facebook хаяг, “Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тамгын газар” “Замын-Үүд сум дахь шүүхийн эвлэрүүлэн зуучлал” пэйж хуудсаар дамжуулан иргэдэд дараах мэдээллүүдийг хүргэж ажиллаж байна. Үүнд

-www.court.zamiin-uud.do.gov.mn цахим хуудсаар: Шүүхийн тамгын газрын танилцуулга, тайлан, нэхэмжлэлийн загварууд, архивын үйлчилгээ, шүүх хуралдааны тов, тойм, шилэн данс, шүүхийн цаг үеийн мэдээ, мэдээлэл зэргийг байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох тухай" "Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай" шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг цахим хуудсанд бүрэн байршуулан олон нийтийг мэдээллээр хангаж ажиллалаа.

Мөн www.court.zamiin-uud.do.gov.mn цахим хуудсанд шүүх хуралдааны бичлэг гэсэн цэс үүсгэн “Нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг цахим хуудсанд байршуулах” журмын дагуу дараах байдлаар байршуулан ажилласан байна.




“Санал хүсэлтийн хайрцаг”, “Эвлэрүүлэн зуучлалын санал хүсэлтийн хайрцаг” зэргээр судалгаа авч ажиллалаа.








1. **Тус шүүхийн иргэнд үйлчлэх хэсэгт:**

- Нэхэмжлэлийн загвар болон материалын бүрдүүлбэр
- Өмгөөлөгчдийн мэдээллийн самбар
- Тусгай хэрэгцээт буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай хэрэгцээний хэрэгсэл
- Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тойм мэдээ
- Хууль зүйн туслалцааны хэсэг

2. **Иргэн та хэнд хандах вэ? Самбарт:**

- Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны схем зураг
- Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны схем
- Захиргааны хэргийн хөдөлгөөний зураглал
- Иргэдэд үйлчлэх үйлчлэх үйлчилгээний горим

- Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн зөрчилд хэн гомдол гаргах вэ?





**3.Шүүхийн архивын үйлчилгээ үзүүлэх журам хэсэгт:**

- Архивын үйлчилгээ үзүүлэх
- Архивын үйлчилгээний хураамж
- Хүсэлтийн загвар
- Баталгааны хуудас зэргийг байршуулсан.






**4. Тус шүүхийн киоск төхөөрөмж нь:**

Киоск машиныг хэрэглээнд нэвтрүүлснээр иргэн, хуулийн этгээд нь газрын харилцааны чиглэлээр нийт 16 төрлийн үйлчилгээ, мэдээллийг нэг дороос 1 минутын дотор авах боломжтой болсон байна. Мөн Киоск машиныг ашиглан 52 төрлийн өргөдлийг цахимаар өгөх, 12 төрлийн мэдээлэл, лавлагаа, тодорхойлолтыг хэвлэн авах, мөн цахим хүсэлт өгөх, өргөдлийнхөө явцыг шалгах, цахим гэрээ, гэрчилгээ үүсгэх, газрын төлбөр шалгах, газрын төлбөрөө QR-аар төлөх үйлчилгээнүүдийг авах боломжтой юм.






Мөн тус шүүхийн тамгын газраас иргэд олон нийтийг мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд “Гэрэлт самбар”-ыг шинэчлэн хийж байршууллаа. Уг самбараас иргэд шаардлагатай утасны дугаар, цахим хаяг, нэхэмжлэлийн загваруудыг харах бүрэн боломжтойгоос гадна тус самбараас QR кодыг уншуулан шүүхийн захиргааны ажилтан албан хаагчдыг үнэлэх, шүүхэд итгэх иргэдийн судалгааг бөглөх, өдөр шөнийн аль ч цагт мэдээлэл авах боломжтой болгож мэдээлэл авах хүрээг өргөтгөж технологийн шийдлийг ашигласан нь давуу талтай юм.

Иргэд шаардлагатай бол нэхэмжлэлийн загвар болон бусад мэдээллийг хэвлүүлж авах боломжоор хангаж өглөө.





“Шүүхийн өөртөө үйлчлэх танхим”-аас:

Шүүхийн архивын үйлчилгээ, иргэд хүлээн авах цагийн хуваарь, мэдээлэл лавлагааны утас, өмгөөлөгч нарын утасны дугаар бүхий танилцуулга, Эвлэрүүлэн зуучлалын утас, танилцуулга, шүүх хуралдааны зар, тойм, шүүгчийн ёс зүйн зөрчилд гомдол гаргах танилцуулга, шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд гомдол гаргах журам, авлигын мэдээлэл авах утас, тухайн шүүхийн цахим хаяг болон Judcouncil.mn, Shuukh.mn сайтуудын хаяг мэдээллүүдийг авах бүрэн боломжтой юм. Дээрх мэдээллүүдийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.






Энэхүү цахим системээс шүүхээр үйлчлүүлж байгаа иргэд дараах мэдээллийг авах боломжтой. Үүнд:

- Нэхэмжлэлийн загвар
- Шүүхийн харъяалал
- Видео шторк
- Шүүхийн цахим хуудас
- Шүүхийн захиргааны ажилтны үнэлгээ
- Санал асуулга
- Шүүхийн фейсбүүк хаяг
- Үйл ажиллагааны тайлан

Иргэд www.court.zamiin-uud.do.gov.mn сайтаар нэвтрэн орж шүүхийн захиргааны ажилчдыг үнэлэх боломж бүрдсэн.

Мөн тус шүүхээр үйлчлүүлж байгаа иргэд “цахим хөтөч” буланд хандаж шүүхийн захиргааны ажилтнуудын /мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, шүүгчийн туслахууд, эвлэрүүлэн зуучлагчийн туслах, архив-бичиг хэргийн эрхлэгч/ харилцаа, хандлага болон мэдлэг ур чадварт сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх боломж бүрдсэн. Цаашид энэхүү иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг нэгтгэн шүүхийн захиргааны ажилтнуудын улирал, хагас жил, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайлан болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхэд нэг үзүүлэлт болгон ашиглах боломжтой юм.




/Захиргааны ажилчдыг үнэлэх цонхны харагдах байдал/

Тус шүүхийн иргэд өөртөө үйлчлэх хэсэгт "Шүүхэд гаргах нэхэмжлэлийн загвар", "Тусгай ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх нэхэмжлэлийн загвар", Дорноговь аймаг болон Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулдаг өмгөөлөгчдийн мэдээллийг тус тус байршуулан иргэдийг мэдээллээр хангаж ажилласан.








**Олон нийтийг мэдээллээр хангах, сургалт, өдөрлөг зохион байгуулах**

Монголын Хуульчдын холбоо жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийг "Хуульчийн Про Боно өдөр” болгон зарлаж, Монгол орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэсэн. Иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгөх зорилготой тус арга хэмжээ 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тамгын газраас "Нээлттэй шүүх" өдөрлөг зохион байгууллаа.

Тус өдөрлөгийн хүрээнд иргэдэд Анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, иргэний ажиллаж байсан байдлаа тогтоолгох, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох, зээлийн төлбөр гаргуулах, ажилд эргүүлэн томилуулах, ажилгүй байсан хугацааны нөхөн олговор гаргуулах зэрэг нэхэмжлэлийг шүүхэд хэрхэн гаргах, бүрдүүлэх баримт материал болон шүүхийн архивын үйлчилгээний талаар 12 иргэнд дэлгэрэнгүй мэдээлэл өгч мөн өмгөөлөгч С.Энхзул, Д.Энхтуяа нар 10 иргэнд үнэ төлбөргүй зөвлөгөө өгч ажиллалаа.










Шүүхийн тамгын газраас мэдүүлэх эрхийг эрх, зөрчлийн тухай хууль, иргэдийн төлөөлөгчийн тухай ойлголт, эвлэрүүлэн зуучлах ажиллагааг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах ажлын хүрээнд олон нийтийг мэдээллээр хангаж дараах ажлуудын зохион байгуулж ажиллалаа. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах ажлын хүрээнд Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын ажилтан алба хаагч нар болон иргэдэд Тухайн сумдын иргэдэд шүүхийн хэргийн хөдөлгөөний мэдээг танилцуулж, "Иргэдийн төлөөлөгчийн тухай ойлголт", "Эвлэрүүлэн зуучлалын тухай ойлголт", "Шүүхийн архивын үйлчилгээний журам болон шүүхийн архиваас хуулбар, лавлагаа авах тухай ойлголт" зэрэг сургалтуудыг зохион байгуулж, иргэдээс гаргасан нэхэмжлэлийг хүлээн авч ажиллаа. Мөн иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч ажилласан.





**/Замын-Үүд сумын 1-7 дугаар цэцэрлэгийн ажилтан, албан хаагч, эцэг эхчүүдэд нарт сургалт хийж буй байдал/**



**/Сайншанд татах хэсэг Замын-Үүд эргэх Депод сургалт хийж буй байдал/**





/Замын 4 дүгээр ангийн 17 дугаар хэсгийн албан хаагч нарт сургалт орж буй байдал/





/Замын-Үүд сумын өртөө болон Пто цехийн ажилтан албан хаагч нарт сургалт хийж буй байдал/





/Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг болон Борхойн наран өрхийн эрүүл мэндийн төдийн эмч, сувилагч нарт сургалт хийж буй байдал/





**/Замын-Үүд сумын Цахилгаан түгээх сүлжээ ТӨҮГ-н ажилтан алба наагч нарт сургалт хийж буй байдал/**

Шүүхийн тамгын газрын зүгээс Эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг онцгой анхаарч дэмждэг. Харьяалан ажилладаг сумдад болон нутаг дэвсгэр дэх холбогдох байгууллагуудад сургалтуудыг удаа дараа эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сурталчлан таниулснаар иргэдээс шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид хандах хандлага, харилцаа өсөж шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачааллыг бууруулж ажилласан байна.









**/Эрдэнэ, Өргөн суманд сургалт хийж буй байдал/**

**"Дадлагажигч сурагч" өдөрлөг зохион байгууллаа**

Дорноговь аймгийн Болосролын газраас 9-12 дугаар ангийн сурагчид ирээдүйн мэргэжил, зорилгоо тодорхойлох, өөрийн боломж чадвар, нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан ажил мэргэжлээ зөв сонгоход чиглүүлэх зорилгоор "ДАДЛАГАЖИГЧ СУРАГЧ" үйл ажиллагааг зохион байгуулж 2025.11.10-ны өдөр Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2, 3 дугаар сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчид Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн үйл ажиллагаатай танилцаж. Эрх зүйч мэргэжлийг сонгосноор ямар, ямар ажил хийх боломжтой, шүүгч, шүүхийн захиргааны ажилчид ямар ажил хийдэг талаар нээлттэй ярилцаж, тэднийг сонсох үйл ажиллагаа зохион байгууллаа.






***/ ДАДЛАГАЖИГЧ СУРАГЧ** өдөрлөгийн үеэр/*

Ерөнхий боловсролын сургуулийн 11 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулсан хууль сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурагчдад эрх зүйн боловсрол олгох “БИ ХУУЛЬЧ” өдөрлөгийг зохион байгуулж, зохиомжит шүүх хуралдаан хийв.







## Дүн шинжилгээ

Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг мэдээллээр хангах, арга хэмжээний хүрээнд иргэдэд шүүхийн үйл ажиллагааг хүргэх зорилгоор Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх **https://www.court.zamin-uud.do.gov.mn** цахим хуудасны "ИРГЭН ТАНД" цэс дотор "НЭХЭМЖЛЭЛИЙН ЗАГВАР" хэсэгт 12 нэхэмжлэлийн загвар болон эвлэрүүлэн зуучлагчид гаргах өргөдлийн загвар, тус шүүхийн "**ЗАМЫН-ҮҮД ШҮҮХ**" фэйсбүүк хуудсанд 23 нэхэмжлэлийн загвар, тусгай ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх нэхэмжлэлийн загварууд, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлтийн загвар-1, шүүгчийн захирамжийг албадан гүйцэтгүүлэх хүсэлтийн загвар 1-г тус тус байршууллаа.

Ийнхүү иргэд, аж ахуй нэгж, байгууллагыг цахим мэдээллийн хэрэгсэл, телефон утсаар дамжуулан мэдээллээр хангаж ажилласнаар тус шүүхэд ирүүлсэн 844 нэхэмжлэлийн 498 нэхэмжлэлийг шуудангаар ирүүлсэн бөгөөд шүүхийн цахим хаягтаа тавьсан нэхэмжлэлийн загварын мэдээллээс харж нэхэмжлэлийн бүрдүүлбэрээ хангасан байна. Энэ нь тухайн оролцогчдыг шүүхэд биечлэн ирж үйлчлүүлэхэд зарцуулах цаг хугацаа болон шүүхэд ирж үйлчлүүлэх зардлыг хэмнэхэд үр дүн гарч байгаа гэж үзэж байгаа юм.

2025 онд цахим хуудсыг эмх цэгцтэй хөтөлж, шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан, иргэдийг мэдээллээр  хангах үйлчилгээ цэсийн тоог нэмэгдүүлж, тогтмол шинэчлэх ажлыг улам сайжруулан ажиллана.

## Нэгдсэн дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил сайжруулах санал

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн Тамгын газрын 2025 онд хууль болон Шүүхийн Ерөнхий зөвлөлийн холбогдох эрхийн актууд, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу биелэлтийн тайлангаа гаргаж шүүгч, ажилтнуудад танилцуулж, та бүхэнд хүргүүлж байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор шүүх хуралдааны тов, тойм, явцын мэдээллийг цахим сүлжээгээр дамжуулан хэргийн оролцогч, иргэд, олон нийтэд шууд мэдээлэх боломж бүхий “Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим систем /live/shuukh/mn/” системээр дамжуулан иргэд, олон нийтийг шүүх хуралдааны тов, тойм, явцын мэдээллээр шуурхай хангаснаар Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөний 3.3.3-т заасан “Цахим шүүхийг хөгжүүлэх”, 3.5.9-д заасан “Иргэд шүүхэд цахимаар хандах, мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх” зорилтыг хэрэгжүүлж ажилласан. Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиглэлээр шүүхийн дотоод журмын биелэлтийг хангах ажиллагаа бүрэн хийгдсэн, шүүхэд ирсэн хэрэг, гомдол хүсэлтийг хүлээн авах, эрх зүйн актыг хэргийн оролцогчдод хүргүүлэх, тайлан, мэдээ, судалгаа гарах ажиллагаануудыг цаг тухай бүрд тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллалаа. Хамт олны хурал, шуурхай зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж, хэлэлцэх асуудлын хүрээг зөв тодорхойлж, хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тогтмол хангуулж ажилласнаар төлөвлөсөн ажил тасалдах, хойшлох тохиолдол гараагүй болно.

Шүүгчдийг хэргийн ачааллаас хөнгөвчилж, шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эрчимжүүлэх, иргэдэд шүүхийн эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны давуу талыг ойлгуулах хүрээнд иргэдэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сурталчлах, танин мэдүүлэх сургалтуудыг удаа дараа зохион байгуулж ажилласан.

Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийн хүрээнд эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд дэг сахиулагчийг тогтмол оролцуулж аюулгүй байдлыг хангаж ажиллалаа.

2025 онд Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх нь 4 шүүгчийн орон тоотой ажиллахаас 2 шүүгч ажилласан. 2025 оны 05 сарын 15-ны өдрийн 60 дугаар Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгч Д.Цэдэнпэлжээ нь өндөр насны тэтгэврт гарсан. 1 шүүгчийн орон тоотой ажиллаж байгаагаас үүдэн өөр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч нар бүрэлдэхүүнд ирж томилолт, шатахууны зардал их гарсан. Иймд дээрх орон тоонуудыг нөхөн томилох хэрэгцээ үүсэж байна.

Үүнээс гадна Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын Ерөнхий газраас ирүүлж буй албан бичигт шинжээчийн зардлыг 840,000-1,794,000 төгрөгөөр тооцсон ба уг зардлыг шүүхээр гаруулсны дараагаар шинжээчийн дүгнэлт гаргана гэсэн албан бичгийг удаа дараа ирүүлсэн. Үүнээс улбаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хугаандаа хэрэгжихгүй байгаа нөхцөл байдал үүсээд байна. Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс жилд шинжээчийн зардлыг 500,000-1,000,000 төгрөгийн хооронд төсөвлөсөн байдаг. Гэтэл төсөвлөсөн зардал нь нэг хэргийн ч шинжээчийн дүгнэлт гаргуулах зардалд хүрэлцэхгүй нөхцөл байдал үүсэж байгаа тул 2026 оны төсвийг батлахдаа хүрэлцэхүйц хэмжээнд баталж өгөх шаардлага гарч байна.

Цаашид бид шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг бүрэн хангаж хэрэг хянан шийдвэрлэх үе шат бүрийн ажлыг мэдлэг, туршлага, хариуцлагын өндөр түвшинд гүйцэтгэж хэргийн хөдөлгөөний үе шат бүрд тавих хяналтыг сайжруулж дотоод хяналт шинжилгээ үнэлгээг сайжруулах нь чухал гэдэгт дүгнэлт хийж ажиллана.

2026 онд иргэдийн мэдэх эрхийг цахим дэвшилтэд болон уламжлалт аргаар бүрэн хангасан, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангасан, үйлчилгээний зөв соёл төлөвшүүлсэн, шүүхээр үйлчлүүлэгч иргэдийн тав тухтай байдлыг хангасан, ажилтан албан хаагчдаа ажиллах нөхцөл боломжийг бүрэн хангасан жил байхаар төлөвлөж зорилго болгон ажиллана.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тамгын газар нь 2026 оны Шүүхийн Ерөнхий зөвлөлийн зорилтууд болон Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын хэрэгжүүлэх арга хэмжээг дэмжиж бүрэн хэрэгжүүлэх зорилтыг тавьж байгаа болно.

**2026 оны ажил сайжруулах санал:**

- ✓ Цахим мэдээллийн хуудсуудын хөтлөлтийг сайжруулан ажиллах, видео контент, подкаст хийж иргэдэд хүргэх,
- ✓ Төрийн албаны тухай хууль тогтоомжид нийцсэн болоны "Шүүхийн захиргааны ажилтан бэлтгэх сургалт"-д хамрагдсан иргэдээс шүүхийн хүний нөөцийг бүрдүүлж ажиллах,
- ✓ Цахим архивын системийг эрчимжүүлэх,
- ✓ Шүүхийн тамгын газрын өдөр тутмын үйл ажиллагааг хянах,
- ✓ Захиргааны ажилтныг тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх харилцааны соёл, сахилга хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах,
- ✓ Иргэдийн төлөөлөгчдийн нэрс шинэчлэгдсэнтэй холбогдуулан шинээр сонгогдсон иргэдэд иргэдийн төлөөлөгчдийн сургалтыг баг, сумдаар очиж зохион байгуулна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.ХОНГОРЗУЛ